



**ХАН АЛТАЙ РЕСУРС ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-021537/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 6413811/

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ЫН
МЭРГЭЖИЛТЭН: _____

/Ц.ЖАРГАЛНЭМЭХ/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ХАН АЛТАЙ РЕСУРС" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: _____



/Ц.БАТПҮРЭВ/

ХАН АЛТАЙ РЕСУРС" ХХК-ИЙН
ЭМААБООНЗ ГАЗРЫН ЗАХИРАЛ: _____

/М.МӨНХ-ЭРДЭНЭ/

2023 он

ГАРЧИГ

БҮЛЭГ НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
1.1 ХАН АЛТАЙ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	10
1.1.1. Хан Алтай” төслийн тухай товч мэдээлэл	10
1.1.1. Хан – Алтай төслийн зэс-алтны бүлэг ордуудын геологийн тогтоц	12
1.1.3. Хан – Алтайн техник эдийн засгийн үндэслэл	14
1.1.4. Ил уурхай	14
1.1.5. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох	16
1.1.6. Баяжуулах үйлдвэр.....	16
1.1.7. Дэд бүтцийн байгууламж	20
1.2 ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	26
1.2.1. Газрын гадарга.....	26
1.2.2. Уур амьсгал	26
1.2.3. Гадаргын ус.....	26
1.2.4. Гүний ус	26
1.2.5. Хөрсөн бүрхэвч	26
1.2.6. Хур тунадас	27
1.2.7. Ургамлын аймаг	27
1.2.8. Амьтны аймаг	27
1.2.9. Тусгай хамгаалалттай газар нутаг.....	27
1.2.10. Нийгэм-эдийн засаг.....	27
1.3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	28
1.3.1 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ	28
1.3.2 Уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ.....	30
1.3.3 Агаарын чанарт үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл.....	32
1.3.4 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ	35
1.3.5 Гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ ..	39
1.3.6 Ургамлан бүрхэвчинд үзүүлэх гол болон сөрөг нөлөөлөл, үнэлгээ.....	42
1.3.7 Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ.....	46
1.3.8 Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ	49
1.4 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	53
1.4.1. Байгаль хамгаалах ажлын зорилго, зорилт:.....	53
1.4.2. Хамрах хүрээ:	53
БҮЛЭГ ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	54

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	54
2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй	57
2.1.1. Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх боломжтой дулааны улиралд усалгааг байнга хийх, хуваарь гаргах.....	57
2.1.2. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын сайжруулалт засвар, үйлчилгээ хийх	58
2.1.3. Химийн бодисыг шатах, гал авалцах эх үүсвэр болон хамт хадгалж болохгүй бодисуудыг тусад нь хадгалах.....	60
2.1.4. Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах	61
2.2. Гадаргын болон газрын доорх усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	64
2.2. Гадаргын болон газрын доорх усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй.	68
2.2.1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ус ашиглахдаа үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны батлагдсан нөөц болон усны боломжит нөөцөөс хэтрүүлэн ашиглахгүй байх.	68
2.2.2. Төслийн талбайн мониторингийн цоонгогт автомат түвшин хэмжигч суурилуулах.....	69
2.2.4. Үйлдвэрлэлийн болон унд ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа худгуудын тоолуурын бүрэн бүтэн байдлыг хангах.....	70
2.2.5. Орон нутгийн захиргааны байгууллагуудтай зөвшилцөн булгийн эхийг хашиж хамгаалах	72
2.2.6. Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах далан байгуулах.	72
2.2.7. Төслийн хүчин чадалд тохирсон бага оврын ахуйн бохир ус цэвэрлэх.....	73
2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	74
2.3. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй	78
2.3.1. Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх, дахин боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан нийлүүлэх.....	78
2.3.2. Үйлдвэрийн бүсэд ашиглагдах ердийн шороон замуудыг тэмдэгжүүлэх	79
2.3.3. Шатах тослох материал асгарсан тохиолдолд шингээж авах, цэвэрлэх элс, хүрз гэх мэт материал багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах	80
2.3.4. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй химийн бодисын бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх, химийн бодис хөрсөнд алдагдаж бохирдолд үүссэн тохиолдолд саармагжуулах болон цэвэрлэх, цэвэрлэгээний дараах хяналт мониторинг хийх.....	81
2.3.5. Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх	81
2.4. Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	83

2.4. Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй.....	85
2.4.1. Нүүрсний талбайг хайргажуулах, хашаа хамгаалалт хийх газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	85
2.4.2. Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхийн өмнө “Газар хөндөх зөвшөөрөл”-ийг өгөх	85
2.4.3. Зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэж, зөрчлийг арилгах, шаардлагатай арга хэмжээг авах:	86
2.5. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	87
2.5. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй.....	90
2.5.1. Замын хажуугаарх ургамлыг тоосжилтод өртөхөөс хамгаалж, замын арчилгааг хийснээр ургамалжилтад учруулах сөрөг нөлөөллийг хамгийн доод хэмжээнд байлгах, хучилтгүй зам дээр явах машины хурдыг хязгаарлах.....	90
2.5.2. Уурхайн талбай орчмын ургамлан нөмрөг, төрөл зүйлийн нарийвчилсан судалгаа хийх.	90
2.5.3. Цөлжилттэй тэмцэх үндэсний өдрийг орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах.....	91
2.5.4. Мод тарих үндэсний өдрийг 5,10 сард зохион байгуулж уурхайн ногоон байгууламжыг нэмэгдүүлэх	92
2.5.5. Орон нутгийн байгууллагатай хамтран уурхай орчмын ургамлын үр түүх, үрийн фонд үүсгэх.....	94
2.6. Амьтан аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	96
2.6. Амьтан аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй	99
2.6.1. Орон нутагт ан хийхийг хориглох, галт зэвсэг хэрэгсэл байлгахыг хориглох талаар сурталчилах.....	99
2.6.2. Тухайн нутагт нутагладаг зэрлэг амьтад болон мал үйлдвэрийн талбайд орох ухаш, шуудуунд унаж бэртэх, хорогдохоос урьдчилан сэргийлэх, нуруулдан уусгалтын талбайд шувуу үргээгч байрлуулах.	100
2.6.3. Нуруулдан уусгах байгууламж, баяжуулах үйлдвэрийн хэсэгт ан амьтан орохоос сэргийлж хашаажуулах.....	101
2.6.4. Орон нутгийн байгууллагуудтай хамтран зэрлэг ан амьтанд өвөл, хаврын үед биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	102
2.6.5. Зэрлэг ан амьтанд зориулан Нарны өргүүртэй худаг, гаргаж орон нутгийн байгууллагад хүлээлгэн өгөх, автомат камер суурилуулан мониторинг хийх	103
2.6.6. Орон нутгийн байгууллагатай хамтран “ Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээ”-ний хөтөлбөрийг хэрэгжүүлэн уурхай орчмын малчин иргэдтэй хамтран амьтаны ажиглалт судалгаа хийх	103
2.6.7. Уурхайн амьтаны нарийвчилсан судалгаанд үндэслэн тарвага нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	104
БҮЛЭГ ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	106

3.1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй	108
3.1.1. Уул олборлолтын бүсэд ашиглагдахгүй болсон зам талбайд техникийн нөхөн сэргээлт хийх.	108
3.1.2. “Нөхөн сэргээлт” 2020 арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд хуурай үрлэгч ашиглан олон наст үр цацах	108
3.1.3. Үржил шимт хөрсийг хуулж, 5 м-ээс өндөргүй овоолго үүсгэн хадгалах.....	109
3.1.4. Үржил шимт хөрсийг сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс, уулын нугат хээрийн болон уулын нугын хөрсөөр 2 ангилан хэлбэржүүлэх	109
ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	111
4.1. “Нөхөн сэргээлт” 2020 арга хэмжээний хүрээнд хууль бусаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх	113
4.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг сонгох.....	114
4.3. Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачлагын хүрээнд ГАА-ийн 108сая мод тарих аянд нэгдэн ГАА-ийн Наран багийн Элгэн булгийг түшиглэн мод үржүүлгийн талбай талбай байгуулах	117
БҮЛЭГ ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	120
5.1. Нүүлгэн шилжүүлэлтийн биелэлт:	121
5.2. Нөхөн олговрын биелэлт:	122
БҮЛЭГ ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	123
6.1. Археологийн судалгааны үр:	123
6.2. Палеонтологийн судалгааны үр дүн:.....	123
6.3. Хэрэгжүүлсэн арга хэмжээ:.....	124
БҮЛЭГ ДОЛОО. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	125
БҮЛЭГ НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	131
8.1. Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах.....	134
8.2. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээг ГАА-ийн хот тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах, мөн дахивар хог хаягдлыг Алтай хотын тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулан нийлүүлэх.	135
8.3. Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах	136
8.4. Аюултай хог хаягдлын менежмент:	138
БҮЛЭГ ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	142
9.1. Хөрсний чанарын хяналт шинжилгээний тайлан:	153
9.2. Усны чанарын хяналт шинжилгээ:	156
9.3. Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо, дундаж өндөр, бүрхэц,%158	
9.4. Орчны физик үзүүлэлтүүдийн мониторинг	163

БҮЛЭГ АРАВ. АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	165
БҮЛЭГ АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	166
БҮЛЭГ АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	170

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ордын байршлын зураг	10
Зураг 2. Хүдрийн биетүүдийн ерөнхий байрлал	13
Зураг 3. Ашиглалт явуулах диаграмм	15
Зураг 4. Зам овоолгын суурь	16
Зураг 5. Исэлдсэн хүдэр боловсруулах үйлдвэрийн нуруулдан уусгах талбай.....	17
Зураг 6. Нуруулдан уусгалтын талбайн нэг загварын хөндлөн огтлол.....	18
Зураг 7. Бутлалын хэсгийн технологийн схем.....	19
Зураг 8. Хан Алтай алтны үндсэн ордын байршил	20
Зураг 9. Шатахуун түгээх станц.....	22
Зураг 10. Тэсрэх бодисын агуулахын зураг	22
Зураг 11. Технологийн замын усалгааны хуваарь.....	57
Зураг 12. “Хан Алтай” төслийн талбайн замын сүлжээ	58
Зураг 13. Зам талбайн тоосжилт дарах арга хэмжээ	58
Зураг 14. Зам арчлалтын нэг жилийн хуваарь	59
Зураг 15. Дотоод зам талбайн арчилгаа	59
Зураг 16. Улцангийн давааны зам арчилгаа.....	60
Зураг 17. Химийн бодисын агуулахын дүгнэлт	60
Зураг 18. 19. Химийн бодисын хадгалалт тэмдэг тэмдэглэгээ.....	61
Зураг 20. 21. Химийн бодисын ХАЛМ.....	61
Зураг 22. Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох журам, хавсралт.....	62
Зураг 23. Хор саармагжуулах бүтээгдэхүүн олголт.....	63
Зураг 24. Ус ашиглах гэрээ 2023.....	68
Зураг 25. Усны төлбөр ноогдуулалт	69
Зураг 26. Усны түвшин хэмжигч Solinst Levellogger.....	69
Зураг 27. Суурилуулсан тоолуур, актуудын стандарт хэмжил зүйн гэрчилгээ.....	71
Зураг 28. Тал булгийн эхийг хашиж хамгаалсан.....	72
Зураг 29. Төслийн талбайн үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын зураг	72
Зураг 30. Үерийн хамгаалалтын байгууламжийн ажил	73
Зураг 31. Бохир ус цэвэршүүлэх байгууламжын бүтээн байгуулалт	73
Зураг 32. Ашигласан тос тосолгооны материал түр хадгалах талбай	78
Зураг 33. Аюултай хог хаягдлын бүртгэл	78
Зураг 34. Аюултай хог хаягдлыг Түмэн Эгшиг ХХК-д хүлээлгэн өгч устгуулж байна.	79
Зураг 35. Уурхайн замын тэмдгийн бүртгэл.....	79
Зураг 36. Зам арчлалтын нэг жилийн хуваарь	80
Зураг 37. Асгаралтын иж бүрдэл	81
Зураг 38. Химийн бодисын асгаралтын иж бүрдэл.....	81
Зураг 39. Химийн бодисын тээврийн гэрээ	82
Зураг 40. Төлөвлөж буй нүүрсний талбайн ерөнхий зураг	85
Зураг 41. Газар хөндөх зөвшөөрлийн маягтууд	86
Зураг 42. Хөнгөн тэрэгний сургалт, дромын талбайд шалгалт авч байгаа нь	90
Зураг 43. Ургамалын хээрийн судалгаа	91
Зураг 44. Цөлжилттэй тэмцэх үндэсний өдөр	92
Зураг 45. Намрын мот тарилт төлөвлөлтийн зураг	93

Зураг 46. Намрын бүх нийтийн мод тарилт	93
Зураг 47. Өргөө кемпийн ногоон байгууламж.....	94
Зураг 48. Харган, Хармагны үр түүж байгаа байдал.....	94
Зураг 49. Харган, Хармагны үр түүж цайруулсан байдал.....	95
Зураг 50. Галт зэвсэг хэрэгсэл, ан хийхийг хориглох мэдээлэл.....	99
Зураг 51. Ан хийж байсан үйлдлийг таслан зогсоосон.....	99
Зураг 52. Нуруулдан уусгах байгууламжид байрлуулсан шувуу үргээгч.....	100
Зураг 53. Bird X Peller PRO шувуу үргээгч.....	100
Зураг 54. Цахилгаан дамжуулах агаарын шугам – Шувуу үргээгч	101
Зураг 55. Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн	102
Зураг 56. Худгийн ажлын явц	103
Зураг 57. Төслийн талбайн ан амьтны судалгааны хээрийн судалгааны ажил	104
Зураг 58. Ловонгийн нуруунд тарвага нутагшуулсан ажлын явц.....	105
Зураг 59. Төслийн усан хангамжын нэгдсэн системийн техникийн нөхөн сэргээлт.....	108
Зураг 60. Техникийн нөхөн сэргээлт хийж байгаа нь	108
Зураг 61. Шимт хөрсний овоолго	109
Зураг 62. Есөнбулаг сумын засаг даргын албан хүсэлт	113
Зураг 63. Өгийн гол нөхөн сэргээлт хийх талбай /1.07га/	113
Зураг 64. Шаврын гол Улаан хадны бэлчир /4.52га/.....	114
Зураг 65. Оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт	115
Зураг 66. Хээрийн судалгаа хийсэн байршлын зураг	115
Зураг 67. Хан Алтай төслийн нөлөөлөлд өртөх талбай.....	116
Зураг 68. Мод үржүүлгийн талбайн байршил	117
Зураг 69. Мод үржүүлгийн талбайн ерөнхий төлөвлөгөө	117
Зураг 70. Хүлэмжний хөрс боловсруулалтын ажил.....	118
Зураг 71. Хүлэмжний тарилтын ажил	118
Зураг 72. Тариалалт хийсний дараах байдал	119
Зураг 73. Модны үрсэлгээний ургалт.....	119
Зураг 74. нүүлгэн шилжүүлэлтийн ажил	122
Зураг 75. Хамгаалах ажлын явц	124
Зураг 76. Энгийн хог хаягдлын цэг, ангилан ялгах сав	135
Зураг 77. Энгийн хог хаягдлын гэрээ, хог хаягдал хүлээлгэн өгсөн акт.....	136
Зураг 78. Байгаль орчны талбайн бүрэн зааварчилгаа.....	137
Зураг 79. Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар	138
Зураг 80. Аюултай хог хаягдал устгуулах гэрээ.....	139
Зураг 81. Аюултай хог хаягдал хүлээлгэн өгч байгаа байдал.....	140
Зураг 82. Аюултай хог хаягдал устгуулсан баримт	140
Зураг 83. Эмнэлэгийн хог хаягдлын бүртгэл.....	141
Зураг 84. Химийн бодисын сав, баглаа боодлын хаягдал цуглуулах түр контейнер.....	141
Зураг 85 Байгаль орчны хяналт шинжилгээ	147
Зураг 86 Агаар дахь химийн үзүүлэлт тодорхойлолт	152
Зураг 87. Уурхайн талбай болон хээрийн судалгаа хийсэн замнал.....	159

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байрзүйн солбицлууд.....	12
Хүснэгт 2. Төслийн мэдээлэл.....	12
Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	14
Хүснэгт 4. Уурхайн замын урт.....	15
Хүснэгт 5. Исэлдсэн хүдэр олборлолт	18
Хүснэгт 6. Уурын зуухны техникийн үзүүлэлт.....	23
Хүснэгт 7. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ	28
Хүснэгт 8. Уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ	30
Хүснэгт 9. Агаарын чанарт үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл.....	32
Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах.....	35
Хүснэгт 11. Гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ	39
Хүснэгт 12. Ургамлан бүрхэвчинд үзүүлэх гол болон сөрөг нөлөөлөл, үнэлгээ	42
Хүснэгт 13. Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ.....	46
Хүснэгт 14. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдал, үнэлгээ	50
Хүснэгт 15. Тоосноос хамгаалах нэг бүрийн хамгаалалх хэрэгсэл олголт.....	62
Хүснэгт 16. Олгогдсон газар хөндөх зөвшөөрөл 2023 онд	86
Хүснэгт 18 Агаарын чанарын хяналт шинжилгээний цэгийн жагсаалт	148
Хүснэгт 19 Хөрсний химийн үзүүлэлтүүдийн дэвсгэр утга.....	153
Хүснэгт 20. Судалгааны талбайд бүртгэгдсэн ургамлын ангиллын бүтэц.....	160
Хүснэгт 21. Овог тус бүрд эзлэх зүйлийн бүрэлдэхүүн, эзлэх хувь (%).....	160
Хүснэгт 22. Ховор ургамлын жагсаалт	162

ГРАФИК МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

График 1. Төслийн зам талбайн тоосжилт дарах зориулалтаар ашигласан усны хэмжээ.....	57
График 2. Мод үржүүлгийн газарт ойн зурвас, их ургамлын талбай байгуулсан хэмжээ	92
График 3 Өргөө кемпийн орчим тарьсан модны хэмжээ	92
График 4 Нөхөн олговрын гэрээний статус.....	121
График 5 Нүүлгэн шилжүүлэлтийн статус	121
График 6. Алтай хотын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэсэн хог хаягдлын хэмжээ.....	135
График 7 БОАЖЯ ажлын хэсгийн "Хан Алтай" төслийн талбайд хийгдсэн дээжлэлтүүд.....	147
График 8 Агаар дахь хүчил төрөгчийн хэмжээ	149
График 9 Агаар дахь хүхрийн ислийн хэмжилт.....	149
График 10 Нүүрс төрөгчийн дутуу ислийн хэмжилт.....	149
График 11 Аммиакийн хэмжилт	149
.График 12 Агаар дахь метаны агуулга	150
График 13 Агаар дах Хүхэрт устөрөгчийн хэмжилт.....	151
График 14 Агаар дахь Нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжилт	151
График 15 Агаар дах тоосонцорын хэмжээ PM 2.5, PM 10 нарийвчлалаар	152
График 16 Хөрсөн дэх хүнцлийн агууламж	154
График 17 Хөрсөн дэх хромын агууламж.....	154
График 18 Хөрсөн дэх кобальтын агууламж.....	154
График 19 Усны түвшин хэмжилтийн үр дүн	156
График 20 Усан дах Калцийн агууламж	157


График 21 Усан дах Магнийн агууламж.....	157
График 22 Усан дах Сульфатын агууламж.....	157
График 23 Усан дах Нитрит агууламж.....	158
График 24. Бүртгэгдсэн зүйлүүдийн овгийн бүрэлдэхүүн.....	161
График 26 Харьцангуй чийгшлийн хэмжээ.....	163
График 27 Дуу чимээний хэмжилт.....	163

БҮЛЭГ НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ХАН АЛТАЙ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хан Алтай алтны үндсэн орд нь Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун урд зүгт 1000км-т, Алтай хотоос зүүн урагшаа 95 км-т, Бигэр сумын төвөөс баруун хойшоо 50 км-т байрладаг. 2010 оноос Макс групп нь алт, зэсийн хайгуулын ажлыг хайгуулын лиценз бүхий талбайнуудад хийж эхэлсэн бөгөөд 2018 онд Хан Алтайн алтны орд газрыг нээн илрүүлсэн. “Хан Алтай Ресурс” ХХК-ийн эзэмшиж буй MV- 021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн солбицлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

1.1.1. Хан Алтай” төслийн тухай товч мэдээлэл



Зураг 1. Ордын байршилн зураг

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1.	Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“ХАН АЛТАЙ РЕСУРС” ХХК
	Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	Гэрчилгээний дугаар: 9011361005 Регистрийн дугаар: 6413811
	Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа Бүртгэсэн он сар өдөр: 2019.04.01
	Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Улаанбаатар хот, 5-р хороо, Самбуугийн гудамж, М Плаза, 17 давхар Утас: 7777-2727 Электрон шуудан: info@khanaltai.mn Вэб хуудас: www.khanaltai.mn
	Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Гүйцэтгэх захирал: Ц. Батпүрэв Утас: 8810-1957 Цахим шуудангийн хаяг: batpurev.ts@khanaltai.mn
	Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	“Хан Алтай ресурс” ХХК – Байгаль орчны ахлах мэргэжилтэн Т. Оргилсайхан Утас: 8807-3601 Цахим шуудангийн хаяг: orgilsaikhan.t@khanaltai.mn

1.2.	Төслийн нэр	“Хан Алтайн алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах, исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах, анхдагч сульфидын хүдрийг флотаци – уусгалтын хосолмол технологээр боловсруулах үйлдвэрийн” төсөл
	Төслийн харьяаллын байршил	Хан Алтай алтны үндсэн орд нь Говь Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун урд зүгт 1000 км-т, Алтай хотоос зүүн урагшаа 95 км-т Бигэр сумын төвөөс баруун хойшоо 50 км-т байрладаг.
	Төслийн ангилал	
	а. Нүүрс, алт, жонш, төмрийн хүдэр гэх мэт	Алтны үндсэн орд
	б. Ил уурхай, далд уурхай, шороон орд	Ил уурхай
	в. Баяжуулах үйлдвэр	Хүдэр баяжуулах үйлдвэртэй
	Төсөл эхэлсэн огноо	2020 онд
	Төсөл хэрэгжих хугацаа	10 жил
	Уурхайн хаалт эхлэх огноо	2030 он
	Хаалтын дараах зориулалт	Бэлчээрийн зориулалтаар
	ТЭЗҮ баталсан огноо	2023 он № 01 Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаал
	Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	Хан Алтай алтны үндсэн ордын ил уурхайн исэлдсэн хүдэр баяжуулах үйлдвэр одоогоор ашиглалтад ороогүй байгаа бөгөөд 2021 онд бүтээгдэхүүн хэмжээ байхгүй. Урьд онд нийт 417.65 мян.тн хүдэр олборлосон.
	Ажилчдын тоо	“Хан Алтай ресурс” ХХК-ны үндсэн ажилчдын тоо – 600
	Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	“Хан Алтай ресурс” ХХК-ийн уулын ажлын төлөвлөгөө
	Тухайн төсөлд хамаарах дэд бүтэц	Хүдэр баяжуулах үйлдвэр, Нуруулдан уусгах байгууламж, Цахилгаан дамжуулах дэд станц, Урвалжын агуулах, Уурын зуухны барилга байгууламжууд
	Замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл	Технологийн зам 18.9 км бусад 8.3 км
	шатахуун түгээгүүрийн тоо	Стандартын дагуу баригдсан – 1 ш Нэмэлт тоноглолууд шаардлагын дагуу угсрагдсан Галын гидрант – 2 ш Ачих насосны саравч: 2,0 м*2,0 м Буулгах насосны саравч: 2,0 м*2,0 м Түгээгүүрийн саравч: 7,0 м*10,0 м Аянга зайлуулагч – 3 ш
шатахууны агуулахын агууламжийн хэмжээ	100 шоо метрийн багтаамжтай 6 ш хэвтээ ил сав 25 шоо метрийн багтаамжтай 1 ш хэвтээ далд сав 10 шоо метрийн 1 ш хэвтээ далд ослын сав 10 шоо метрийн 1 ш хэвтээ хаягдал тосны сав	
тэслэх, дэлбэлэх бодисын үйлдвэрийн хүчин чадал гэх мэт	Эмульс 6000 хайрцаг, Өдөөгч – 5616 тн	

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байрзүйн солбицлууд

Д/д	Уртраг			Өргөрөг			Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек		град	мин	сек	град	мин	сек
1	96	56	42	46	3	15.66	12	96	59	9.24	46	5	26.5
2	96	57	5.9	46	3	15.66	13	96	59	9.24	46	6	58
3	96	57	5.9	46	3	35.7	14	96	53	16	46	6	58
4	96	57	29.6	46	3	35.7	15	96	53	16	46	5	11
5	96	57	29.6	46	4	8.8	16	96	49	42	46	5	11
6	96	57	53.4	46	4	8.8	17	96	49	42	46	3	3
7	96	57	53.4	46	4	50.09	18	96	53	27	46	3	3
8	96	58	17	46	4	50.09	19	96	53	27	46	2	39
9	96	58	17	46	5	10.3	20	96	56	18.2	46	2	39
10	96	58	41	46	5	10.3	21	96	56	18.2	46	2	55.37
11	96	58	41	46	5	26.5	22	96	56	42	46	2	55.37

Төслийн тодорхойлолт:

Хүснэгт 2. Төслийн мэдээлэл

Төслийн мэдээлэл	Үйл ажиллагааны чиглэлийн тодорхойлолт
Төслийн нэр	Хан-Алтайн алтны үндсэн ордын исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах, анхдагч сульфидын хүдрийг флотаци - уусгалтын хосолмол технологиор боловсруулах үйлдвэрийн төсөл
Ордын байршил	Алтны үндсэн ордын MV-021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Говь – Алтай аймгийн төвөөс 95 км-т, Бигэр сумаас баруун хойш 50 км-т, Улаанбаатар хотоос баруун тийш 1000 км зайд 6793.28 га талбайг хамран байрлаж байна.
Төсөл хэрэгжүүлэгч	“Хан Алтай Ресурс” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011361005, Регистрийн дугаар: 6413811
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж, М-Плаза төв, 16-р давхар, 1604 тоот. Утас: 99996309

1.1.1. Хан – Алтай төслийн зэс-алтны бүлэг ордуудын геологийн тогтоц.

Хан Алтай ордын хүдрийн биетүүд нь Бөөрийн хөндий дагуух тектоник хагарлын зүүн урд талаар байрладаг. Эдгээр биетүүдэд чулуулгийн төрөл төдийлөн ач холбогдолгүй эрдэсжсэн бүсээр тодорхойлогдоно. Гэвч өөрийн оршин байх байрлал, хүдрийн биетийн хэлбэр зэргээрээ хоорондоо ялгаатай байдлыг үндэслэн хүдрийн биетийн бичиглэлийг ерөнхийд нь 3 бүсэд (Зүүн, Төв, Баруун) ангилан хийжээ.

Хагарал структур:

Хан Алтай алтны үндсэн ордын хүдрийн биетүүд нь Бөөрийн хөндий (хагарал) дагуух зүүн хойш чиглэлийн хагаралтай параллель (магадгүй салбар хагарал) Цахирын тектоник хагарлын зүүн урд талаар байрлана. Бөөрийн хөндийн БХ хэсэгт дунд девоны Цагааншороот формацын элсэн чулуу, алевролит, конгломерат, андезитын нарийн үеүд, харин ЗУ хэсэгт Цахирын тектоник

хагарлаар хянагдсан доод-дунд кембрийн Сатир уул формацын шохойлог зузаалаг, эдиакарийн Улааншанд формацын вулканоген-тунамал хурдсаар зураглагдана.


Хурдас чулуулаг:

Хан Алтай алтны үндсэн ордод хуримтлагдсан хурдас чулуулаг нь гарал үүсэл, текстур, хувирал эрдэсжилтээр ялгаатай олон төрөлд ангилагддаг. Тэдгээрийг геологийн тогтоц, хүдрийн биеттэй харьцаж буй байрлалын онцлог, хувирал, эрдэсжилт, ашигт бүрдвэрийн агуулга зэргийг харгалзан үзэж имплицит аргачлалаар Микромайн 2020 программаар загварчилсан. Чулуулгийн төрлийг ялган тэмдэглэсэн олон төрлийн кодыг нэгтгэн бүлэглэж, голлох 5 төрлийн чулуулаг, 1 дэд судлын бүлгээр литологийн код үүсгэсэн байна. Үүнд:

- Андезитийн туф
- Үеллэг алевролит, элсэн чулуу
- Риолит, туф риолит
- Порфирлог риолит
- Доломитжсон шохойн чулуу

Хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ:

Хан Алтай алтны үндсэн ордын хүдрийн биетүүд нь Бөөрийн хөндий дагуух Цахирын хагарлын зүүн урд талаар байрладаг бөгөөд эдгээр биетүүд нь чулуулгийн литологоос үл хамаарсан хүдэржсэн бүсээр тодорхойлогддог, тектоник хагарлаар хянагдсан, хүдрийн биетийн хэлбэр болон хэмжээгээрээ хоорондоо ялгагддаг. Хүдрийн биетүүдийн бичиглэлийг одоогийн судалгааны түвшинд үндсэн 5 хүдрийн биетийг тогтоогоод байна.



Зураг 2. Хүдрийн биетүүдийн ерөнхий байрлал

Хүдэржилт:

Хан Алтай ордын алтны хүдэржилтийг үндсэн 3 төрөлд ялгасан байна.

- Алт-сульфидийн
- Кварцын судлын
- Цул сульфидийн төрлийн хүдэржилт зэрэг болно.

Ордын нөөцийн тооцоо:

Хан Алтай алтны үндсэн ордод 2019 – 2020 онуудад гүйцэтгэсэн хайгуулын нэмэлт ажлын үр дүнгийн тайланг (Ордын нөөц 2020 оны 05 дүгээр сарын 01-ний байдлаар) ЭБМЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны ХХ-08-10 тоот дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2020 оны 07 сарын 16-ны өдрийн н/65 тоот тушаалаар ордын нөөцийг исэлдсэн хүдэрт алтны захын

агуулга 0.3 гр/тн түвшинд 7,067.83 мян.тн хүдэр, 7,122.59 кг алт, үүнээс бодитой (В) зэрэглэлээр 3,444.55 мян.тн хүдэр, 4,261.41 кг алт, боломжтой (С) зэрэглэлээр 3,623.28 мян.тн хүдэр, 2,861.18 кг алт, анхдагч хүдэрт алтны захын агуулга 0.5 гр/тн түвшинд 35,915.52 мян.тн хүдэр, 32,923.69 кг алт, үүнээс бодитой (В) зэрэглэлээр 12,048.20 мян.тн хүдэр, 11,923.70 кг алт, боломжтой (С) зэрэглэлээр 23,867.32 мян.тн хүдэр, 20,999.99 кг алт, ордын хэмжээнд нийт 42,983.36 мян.тн хүдэр, 40,046.28 кг алт, үүнээс бодитой (В) зэрэглэлээр 15,492.76 мян.тн хүдэр, 16,185.11 кг алт, боломжтой (С) зэрэглэлээр 27,490.60 мян.тн хүдэр, 23,861.17 кг алтны нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

1.1.3. Хан – Алтайн техник эдийн засгийн үндэслэл

Хан – Алтай алтны үндсэн ордын техник-эдийн засгийн үндэслэл нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын ХХ-18-10 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан “Хан Алтай Ресурс” ХХК-ийн Булаг нэртэй XV- 015337 тоот тусгай зөвшөөрлийн талбайд 2010-2019 онуудад явуулсан хайгуулын ажлын үр дүнгийн тайлан (2019 оны 09 сарын 01-ны байдлаар) дахь алтны нөөцийг (В+ С) зэрэглэлээр 17,767.18 кг, үүнээс бодитой В зэргийн нөөцийг 11,969.65 кг- аар, боломжтой С зэргийн нөөцийг 5,797.52 кг-аар нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

1.1.4. Ил уурхай

Уулын ажлыг зогсооход нөлөөлөх давагдашгүй хүчин зүйлийг 12 хоногоор тооцож уурхайн жилд ажиллах горимыг 353 хоног буюу 716 ээлж (8472 цаг) байхаар тооцсон байна. Уурхайн 1 ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Үүний 2 цагт хоолонд орох, ээлж солилцох, тосолгоо үйлчилгээ хийх, түлш цэнэглэхэд зарцуулах хугацаа хамаарна. Тоног төхөөрөмжийн ээлжид ажиллах цэвэр хугацаа дунджаар 10 цаг байна.


Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө: Хан алтай алтны үндсэн ордын ил уурхайгаас тухайн онд нийт 3,212.30 мян.м³ уулын цул үүнээс 3,620.01 мян.тн хүдэр олборлож, 1,854.77 мян.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.51 м³/тн байна.

Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

А/сар	Уулын цул, мян.м ³	Хөрс хуулалт, мян.м ³	Исэлдсэн хүдэр, мян.тн	Анхдагч хүдэр, мян.тн	Нийт хүдэр олборлолт, мян.тн	Хөрс хуулалтын коэфф, м ³ /тн
1	137.87	71.20	177.08	-	177.08	0.40
2	132.29	58.85	159.53	35.83	195.37	0.30
3	304.98	146.71	409.75	10.82	420.58	0.35
4	304.98	251.48	115.61	2.87	118.48	2.12
5	295.23	266.28	98.08	3.98	102.06	2.61
6	304.01	276.64	54.63	15.86	70.48	3.92
7	302.95	238.37	119.71	34.79	154.51	1.54
8	296.56	161.82	272.79	75.95	348.75	0.46
9	274.86	193.61	205.66	8.92	214.58	0.90
10	290.96	10.20	567.57	178.91	746.48	0.01
11	286.30	100.56	382.46	114.03	496.49	0.20
12	292.43	79.05	431.04	144.12	575.16	0.14
Нийт	3,223.43	1,854.78	2,993.92	626.10	3,620.02	0.51

Уурхайн нээлт, ашиглалтын үйл ажиллагаа дараалал

Хан-Алтай алтны үндсэн ордын уурхайн уулын ажилд дараах ашиглалтын дарааллын дагуу явагдана. Уурхайн ашиглалтын хугацаанд хөрс, хүдэр (хүдэр, бага агуулгатай хүдэр), шимт хөрсийг тусад нь овоолго үүсгэн хураана.




Зураг 3. Ашиглалт явуулах диаграмм

Уурхайн гадаад болон дотоод зам.

Хүснэгт 4. Уурхайн замын урт

Үзүүлэлтүүд	1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил	6 жил
	Замын урт, км					
Овоолго	2.5	1.3	2.3	2.3	2.3	2.3
Хүдрийн түр талбай	1.1	1	0.9	1	1	1.1
Баяжуулах үйлдвэр	7.5	7.5	7.5	7.5	7.5	7.5
Далан хүртэлх зам	9.5	9.5	9.5	9.5	9.5	9.5



Зураг 4. Зам овоолгын суурь

1.1.5. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох

Нуруулдан уусгах талбайн суурийг бэлтгэх барилгын ажилд хайрга, шавар ашиглах ба уг түгээмэл тархацтай материалуудыг уурхайн талбайд байрлах орд газруудаас авч ашиглахаар төлөвлөөд байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд тус бүр дээр холбогдох хууль, тогтоомжийн дагуу нөөцийг бодон, байгаль орчны үнэлгээг хийлгэн орон нутагтай гэрээ байгуулах олборлохоор төлөвлөөд байна. Барилгын ажлын төлөвлөгөөний дагуу 2022 онд 48,000 м.куб дайрга, 85,520 м.куб улаан шавар шавар ашиглах тооцоолол гаргаад байна.

1.1.6. Баяжуулах үйлдвэр

Хан Алтай алтны үндсэн ордын исэлдсэн хүдэрт хийсэн баяжигдах шинж чанарын судалгаа, ил уурхайн хүдэр олборлолтын төлөвлөлт зэрэгт үндэслэн Нуруулдан уусгалт-СІС технологиор баяжуулахаар төлөвлөж исэлдсэн хүдэр баяжуулах технологийн тооцоо (масс баланс, усны баланс), бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, тоног төхөөрөмжийн сонголт, урвалж бодисын зарцуулалтын хэмжээ, химийн бодисын агуулахын хэмжээ зэргийг тооцоолж 2022 оны төлөвлөгөөнд тусгасан.


Исэлдсэн хүдэр баяжуулах үйлдвэр

Хан Алтай алтны үндсэн ордын исэлдсэн хүдрийг БНХАУ-ын “Шинхай Майнинг рисерч” лабораторид гүйцэтгэсэн технологийн туршилтын үр дүнд үндэслэн Нуруулдан уусгалт-СІС технологиор боловсруулна.


- | | |
|--------------------------------|-------------------|
| ➤ Исэлдсэн ХБҮ-ийн хүчин чадал | - 3.0 сая.тн/жил |
| | - 8,772 тн/хоног |
| | - 365.5 тн/цаг |
| ➤ Хүдэр бэлтгэх технологи | - 3 шатны бутлалт |

- Бутлагдах хүдрийн ширхэглэл - -400+10 мм
- Исэлдсэн хүдрийн нягт - 2.73 тн/м³
- Бутлагдсан хүдрийн нягт - 1.38 тн/м³
- Нуруулдан уусгалтын нийт талбай - 245,000 м²
- Уусгалтын идэвхитэй талбай - 28,000 м²
- Уусгалтын идэвхигүй талбай - 217,000 м²
- Нурууны өндөр - 8 м (4 үе)
- Хүдэр баяжуулах технологи - Нуруулдан уусгалт-СІС
- Уусмалын нэвчих хурд - 10 л/цаг/м²

Боловсруулах үйлдвэрээс хаягдлыг зутанг насосоор шахаж, шугам хоолойгоор тээвэрлэн хаягдал хадгалах байгууламжинд хаях бөгөөд хаягдлын даланг тойруулан дээрээс цутгах аргын дагуу сан дүүргэлтийг хийнэ. Хаягдлын санд ус цуглуулж хуримтлуулах цөөрөм байх бөгөөд хаягдал зутанд түрэгдсэн, цөөрөмд цугласан усыг зөөврийн гном насосоор эргэлтийн ус нөөцлөх санд цуглуулж баяжуулах үйлдвэр лүү эргүүлэн шахна.



Зураг 5. Исэлдсэн хүдэр боловсруулах үйлдвэрийн нуруулдан уусгах талбай



Зураг 6. Нуруулдан уусгалтын талбайн нэг загварын хөндлөн огтлол

Исэлдсэн хүдэр боловсруулах үйлдвэр


Хан Алтай алтны үндсэн ордын ил уурхайн 2022 онд 1.08 гр/тн дундаж агуулгатай 3.0 сая.тн хүдэр олборлохоор байна.

Хүснэгт 5. Исэлдсэн хүдэр олборлолт

Ашиглалтын сар	Хүдрийн хэмжээ, мян.тн	Дундаж агуулга, гр/тн	Алт, кг
1	177.08	0.90	158.50
2	159.53	0.89	141.64
3	409.75	0.93	382.27
4	115.61	0.53	60.95
5	98.08	0.64	63.05
6	54.63	0.84	45.80
7	119.71	1.10	131.80
8	272.79	1.45	394.60
9	205.66	0.83	170.74
10	567.57	1.46	828.44
11	382.46	1.01	384.82
12	431.04	1.10	476.06
Нийт	2,993.92	1.08	3,238.66

Бутлах хэсгийн технологийн горим

Хан Алтай алтны үндсэн ордын ил уурхайгаас олборлосон -400 мм ширхэглэл бүхий исэлдсэн хүдрийг эхний шатны хацарт бутлуураар -110 мм хүртэл бутлаж, хоёр дугаар шатны конусан бутлуурт шууд тэжээн -35 мм хүртэл бутлана. Хоёрдугаар шатны бутлуурын бутлагдсан хүдрийг 25 мм-ийн тор бүхий чичиргээт шигшүүрээр шигшиж +25 мм ширхэглэлийн бүтээгдэхүүнийг гуравдугаар шатны конусан бутлуурт тэжээнэ. Гуравдугаар шатны бутлуурт +25 мм ширхэглэлтэй хүдрийг -25 мм хүртэл бутлаж эргэлтийн ачаалал болгон чичиргээт шигшүүрт тэжээнэ. Чичиргээт шигшүүрийн -25 мм ширхэглэлийн хүдрийг автосамосвалаар тээвэрлэн нуруулдан уусгалтын талбайн овоолгын талбайд хурааж уусгалтын процесст бэлтгэнэ.




Зураг 7. Бутлалын хэсгийн технологийн схем

Уурхайн технологийн зам

Ил уурхайн талбайгаас исэлдсэн болон анхдагч сульфидын хүдрийн овоолго хүртэлх тээвэрлэлтийн дундаж зай 7.43 км, ил уурхайн талбайгаас хөрсний овоолго хүртэлх тээвэрлэлтийн дундаж зай 0.71 км байна.

1.1.7. Дэд бүтцийн байгууламж

“Хан-Алтай” алтны үндсэн орд нь Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт орших бөгөөд Говь-Алтай аймгийн төвөөс 60 км, Бигэр сумаас баруун хойш 45 км, Тайширын усан цахилгаан станцаас 75 км, Улаанбаатар хотоос баруун тийш 1000 км зайд тус тус оршдог.



Зураг 8. Хан Алтай алтны үндсэн ордын байршил

Хан-Алтайн алтны үндсэн ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэлийн талбайд дараах барилга байгууламжийг байгуулан ашиглана. Үүнд:

1. Ажиллах хүчний орон сууц, үйлчилгээний байгууламж
2. Баяжуулах үйлдвэр
3. Цахилгаан хангамж
4. Захиргаа
5. Засварын газар, агуулах
6. Ус хангамж
7. Шатахуун түгээх станц болон агуулах
8. Тэсрэх материалын агуулах
9. Дулаан хангамжийн нэгдсэн систем
10. Бусад инженерингийн байгууламжуудыг байгуулахаар төлөвлөсөн байна.

Ажилчдын хотхон болон захиргаа:

Уурхайн ажилчдын сууц нь төслийн талбайд байрлана. Төсөл хэрэгжих уурхайн хүчин чадлаас хамааран уурхайд ажиллах боловсон хүчний тоо зохицуулагдсан байна. Ажилчдын сууц нь уурхайн ажилчдын ажлын горим, төсөл эзэмшигч компанийн засаглалын хэлбэр, соёлоос хамааруулан төслийн менежментийн багийн бүтэц, бүрэлдэхүүн ямар байх, оффис-үйлчилгээний барилга байгууламжийн хэрэгцээний төсөөлөл, нийт ажиллагсдын тоо, бүтцийг тодорхойлсны үндсэн дээр орон сууц, соёл- амралт, эрүүл ахуй, ахуйн үйлчилгээний төрөл, хэрэгцээ,

шаардлагыг урьдчилан төсөөлж, боловсруулсан байна. Үйлдвэрийн орон тооны бүтцийн схемээс үзвэл нийт 350 орчим ажилтан ээлжийн амралтын системээр ажиллаж, амьдарна. Уурхайн ажилчдын байранд дараах бүрэлдэхүүн хэсгүүд багтана. Үүнд:

Ажилчдын 150 өрөөтэй амрах байр, нийт 350 хүн байрлах хүчин чадалтай байр

- ✓ Хоолны газар
- ✓ Амралтын байр
- ✓ Уурхайн захиргаа
- ✓ Хөнгөн тэрэгний гараж
- ✓ Шалган нэвтрүүлэх пост
- ✓ Ариун цэврийн өрөө
- ✓ Хувцас угаалгын байр
- ✓ Хөл бөмбөгийн талбай
- ✓ Сагсан бөмбөгийн талбай
- ✓ Спорт заал
- ✓ Газрын теннисийн талбай
- ✓ Уурын зуухны барилга
- ✓ Кемпийн оффис
- ✓ Кемпийн эмнэлгийн барилга
- ✓ Унд усны цэвэршүүлэх байгууламж
- ✓ Бохир ус цэвэршүүлэх байгууламж зэрэг багтана

Уурхайн хүнд машин механизмын засварын газар:

Төслийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг уурхайн талбайд байрлах засварын газар хийж гүйцэтгэнэ.


Ил уурхайн засвар, техникийн үйлчилгээний дэд бүтэц нь тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийхийн зэрэгцээ засвар ашиглалтын хэрэгцээний төрөл бүрийн материал сэлбэг хэрэгсэл, түлш, тос зэргийг хүлээн авч хадгалах, тавьж олгох зориулалттайгаар төсөлд тусгагдсан байна. Засварын газрын талбайн тооцоог хэсэг бүрээр нь үйлдвэрлэл үйлчилгээний технологийн дагуу мөрдөж буй нормативаар авсан байна.

Засвар механикийн цехэд гагнуурын аппарат, ирлэх, харуулах, өнгөлөх, хайчлах зэрэг олон үйлдэлтэй суурь машинууд, гүүрэн кран, тэргэнцрүүд зэрэг тоноглолууд зайлшгүй шаардлагатай.

Засвар механикийн цехийн шал нь бетон бөгөөд хатахдаа резин болдог будгаар бүрэн будаж, засвар механикийн цехийн доторх дугуй засварын хэсэг, гагнуурын хэсэг, угаалга, тосолгооны хэсэг зэргийг тусгаарласан шар будгаар хүрээ гаргасан байна. Гагнуурын хэсэг, угаалга тосолгооны хэсэг нь мөн тусгаарласан төмөр хашлагатай байна.

Шатахуун түгээх станц:


Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт байрлах “Хан Алтай ресурс” ХХК-ийн эзэмшиж буй MV- 021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд баригдсан 600+300 хүчин чадал бүхий Шатахуун түгээх станц болон агуулахын зориулалттай барилга байгууламжыг Говь-Алтай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/584 дугаар захирамжаар томилогдсон барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс хүлээж авсан.



Зураг 9. Шатахуун түгээх станц

Тэсрэх бодисын агуулах:

Хан Алтай Ресурс” ХХК нь Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт орших “Хан алтай” төслийн талбайд түшиглэн үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн байнгын агуулах байгуулан, MV-021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ордын үйлдвэрлэлд шаардлагатай тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг хадгалах, түгээх, олгох зорилгоор өөрсдийн эзэмшлийн талбайд шинээр байгуулах агуулахын зураг төслийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн “Эм Эм Маркет” ХХК боловруулан, Ашигт малтмалын газрын Мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан байна.



Зураг 10. Тэсрэх бодисын агуулахын зураг

Химийн бодисын агуулах:

Химийн бодисын агуулах нь “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандарт шаардлагын дагуу тусгай агуулахын өрөө гарган бэлтгэсэн, 1 давхар, зoorьгүй, газардуулга, аянга зайлуулагчтай, бетон шалтай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хүрэлцээтэй, агаар сэлгэх механик салхивчтай, цонх нь төмөр тортой, гадна талаараа хашаатай, ан цав хотгор гүдгэргүй цементэн шалтай, ус тогтохгүй зэвэрдэггүй будгаар будсан налуу дээвэртэй, агуулахын хана нь химийн бодисоос үүссэн тоос, уур манан тогтохооргүй гөлгөр гадаргуутай, гадна талдаа хаалга болон орчныг тусгасан прожуктор гэрэлтүүлэгтэй, аваарын 2 гарцтай, 24 цагийн харуул хамгаалалттай, хүн ам бага суурьшсан хороолол, усан сан бүхий газар, үер, усны аманд байрлаагүй талбайд хийгдэнэ. Агуулах нь дараах шаардлагыг бүрэн хангасан байна.

Дулаан хангамж:

Төслийн талбай дээрх байгууламж тус бүрийг тусдаа бие даасан дулаан хангамжийн эх үүсвэрээр хангана. Халаалтын улиралд дулаанаар хангах шаардлагатай барилга, объектын хэмжээ:

- ✓ Захиргааны болон засварын барилгын хэмжээ 10220 м³
- ✓ Ажилчдын байр 5508 м³
- ✓ Баяжуулах үйлдвэр 15220 м³

Ажилчдын хотхон болон төслийн барилга байгууламжуудыг дулаан хангамжийг уурын зуухаар (Boiler) халаахаар төлөвлөсөн. Уурхайн барилга байгууламжуудын баригдсан материал хийц зэрэг тусгай шаардлагуудын дагуу халаалтыг түгээнэ.

Хүснэгт 6. Уурын зуухны техникийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
Ажиллах уурын зуухын марк	-	DZL1.4-0.7-95/70-АП
Дулааны чадал	МВт	1.4
Үйл ажиллагааны даралт	МПа	0.7
Гарах температур	°C	95
Эргэж ирэх усны температур	°C	70
Төслийн АҮК	%	80
Уурын температур	°C	172
Үрэлтийн талбай	м ²	3.4
Халаах талбай	м ²	12000
Түлш	Нүүрс	
	Зарцуулалт	кг/цаг
Ус орох болон гарах диаметр	мм	PN1.6, DN100
Овор хэмжээ (LxWxH)	мм	5900x2450x3168
Жин	тн	22.6
	Модел	IS80-65-160

Эргэлтийн усны насос	Хүчин чадал	м ³ /цаг	50	
	Түрэлт	м	32	
	Моторын чадал	кВт	7.5	
Модел		G6-41-13 No5.4a		
Шатаах сэнс	Вентлятор	м ³ /цаг	2130-4358	
	Салхины даралт	Па	994-1254	
	Моторын чадал	кВт	3	
Өдөөгч сэнс	Модел		Y6-41-13 No5.4C	
	Вентлятор	м ³ /цаг	4350-8901	
	Салхины даралт	Па	3240-2568	
	Моторын чадал	кВт	11	

Хог хаягдал:

Исэлдсэн хүдэр боловсруулах үйлдвэр нь эхний 3 жилд нийт 134 хүн, анхдагч хүдэр боловсруулах үйлдвэр нь 3-7 дахь жилүүдэд нийт 188 хүн, уурхайн хотхон, оффист 218 хүн тус тус ажиллана. Ахуйн хатуу хог хаягдалд ажилчдын хотхон, оффис, ахуйн хэрэглээнээс гарч байгаа бүх төрлийн хаягдал хамаарна. Нэг хүн өдөрт дунджаар 0.6 кг хог хаягдал гаргадаг гэж тооцоонд тусгав. Үйл ажиллагааны явцад ахуйн хуурай хог хаягдал эхний 3 жилд сард дунджаар 4.2 тн, жилд дунджаар 50.4 тн, 3-7 дахь жилүүдэд сард дунджаар 7.3 тн, жилд дунджаар 87.6 тн энгийн хатуу хог хаягдал гарах бөгөөд ахуйн хог хаягдлыг тусгайлан зассан хог хаягдал түр хадгалах цэгт цуглуулан сард 1 удаа Есөнбулаг сумын хог хаягдлын нэгдсэн цэгт гэрээ, зөвшөөрлийн дагуу өөрсдийн унаагаар тогтмол зайлуулж байхаар төлөвлөсөн байна.

Ахуйн шингэн хаягдал, зайлуулалт: Хотхонд ашиглах усны нийт хэмжээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалын дагуу тооцоход жилд хамгийн ихдээ 54,395.9 м³/жил цэвэр ус ашиглах бөгөөд ахуйн цэвэр усны 80% нь шингэн хаягдал болдог гэж үзвэл хоногт дунджаар 119.2 м³/хоног, жилд дунджаар 43,516.7 м³/жил шингэн хаягдал гарна.

Иймээс ахуйн бохир ус хуримтлуулах, зайлуулах бага оврын цэвэрлэх байгууламжийг 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан А/82/128 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам” -д заасан шаардлагад нийцсэн 150 м³/хоногоос дээш хүчин чадал бүхий бохирын септик системийг ХБНГУ-ын Busse MF фирмийн ахуйн бохир усыг мембран биоректорын аргаар цэвэрлэх төхөөрөмжийг ажилчдын хотхоны барилга байгууламжийн зураг төсөвт тусгасан.

Исэлдсэн хүдэр боловсруулах үйлдвэрт ашиглах 18 нэр төрлийн 60,845.24 тн урвалж бодис, исэлдсэн хүдэр боловсруулах үйлдвэрийн хяналт шинжилгээний лабораторид ашиглах 37 нэр төрлийн бодис, бүтээгдэхүүн тус бүрийг тооцоонд тусгав. Дээрх химийн бодисын сав,

баглаа боодлын хаягдал нь “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” батлах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 тоот тушаалын хавсралтад зааснаар Сав баглаа боодлын хаягдал бүлгийн “Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав, баглаа боодол” хэсэгт /хог хаягдлын төрлийн код - 15 01 09*/ заасны дагуу аюултай зэрэглэлд хамаарч байна.

Химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнүүд, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна” хэмээн заасны дагуу аюултай хог хаягдлын сав баглаа боодлыг эргүүлэн татаж тээвэрлэх, устгах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий Мэргэжлийн байгууллагатай “Аюултай хог хаягдал тээвэрлэлтийн гэрээ”, “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ”-г байгуулан ажиллана.

Хайгуулын ажлын төлөвлөгөө

MV-021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлт “Хан Алтай” талбайд 2022 онд гүйцэтгэх хайгуулын ажлын хүрээнд дараах төрлийн ажлуудыг хийхээр төлөвлөж байна. (Хайгуулын ажлын аргачлал, ажлын хэмжээ нь судалгааны ажлын үр дүнгээс хамаарч өөрчлөгдөж болно.)

Зураг 1. Хан Алтай талбайд 2022 онд гүйцэтгэхээр төлөвлөж буй ажлын хэмжээ

д/д	Ажлын төрөл	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ
1	Хээрийн судалгааны төлөвлөгөө зохиох	хүн/өдөр	30
2	Өрөмдлөгийн суурь, зам засвар	т.м	15000
3	Шурф нэвтрэлт	т.м	50
4	Баганат өрөмдлөг	т.м	40000
5	Цооногийн бичиглэл	цооног	160
6	Чиглүүлэгтэй өрөмдлөг	цооног	80
7	Керний дээжлэлт	ширхэг	33200
8	Хяналтын дээжлэлт	ширхэг	4500
9	Петрографи, минерографийн дээжлэлт	ширхэг	90
10	Геотехникийн дээжлэлт	ширхэг	100
11	Технологийн дээжлэлт	ширхэг	500
12	Бусад технологийн дээжлэлт	Багц	10
13	Гидрогеолгийн судалгаа	цооног	20
14	Лабораторийн судалгаа	ширхэг	33200
15	Суурин боловсруулалт	хүн/өдөр	200

1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.2.1. Газрын гадарга

Газарзүйн байршлын хувьд Говь-Алтайн нурууны гол хэсэг болох Хантайширын нурууны үргэлжлэл тогтоц Хөх Сэрхийн нурууны баруун урд хэсэгт байрлана. Нурууны хамгийн өндөр цэг нь 3044,9 м өндөр Баян буурал уул, хамгийн нам цэг нь талбайн хилээс урд хэсэгт орших Бигэрийн хөндийн хүрээнд 1300 м байдаг байна. Хөх сэрхийн нуруу нь Алтайн нурууны салбар уулс учраас харьцангуй өндөр ихтэй, уулсын өндөр 300,0-700,0 м-ийн хэлбэлзэлтэй байдаг. Энд 2920,1 м өндөртэй Тахилт овоо байхаас гадна ихэнх уулс нь 2400 м-ээс дээш өндөртэй байна. Бигэрийн хөндий нь томоохон хотгор тогтоц бөгөөд талбай орчимд хөндийн өргөн нь 2-5 км өргөнтэй байна. Хөндийн төвийн хэсгийн 8 км орчим өргөнтэй хэсэг нь шаварлаг хурдсаар дүүргэгдсэн тэгш гадаргатай байдаг бол хөндийн 2 талаар эгц налуу уулын хажуу үргэлжилнэ. Талбайн хойд хэсэг нь Алтайн нурууны үндсэн шинж болох томоохон сархиаг ихтэй, гуу жалгаар ихээхэн хэрчигдсэн, өндөр уулсын төрхийг хадгалж байдаг. Эдгээрийг хэрчсэн жалга, хөндийнүүд нь 100-300 м хүртэлх гүнтэй байдаг.

1.2.2. Уур амьсгал

Цаг уурын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хоногийн болон жилийн хэмийн хэлбэлзэл ихтэй нутагт хамаарна. Зун нь халуун, өвөл нь харьцангуй дулаан байна. Зундаа хамгийн $+38.3^{\circ}$ хүрэх ба дундаж нь $+30^{\circ}$ орчим байна. Өвөлдөө хамгийн их хүйтэн нь -36.5° хүрэх боловч дундаж нь -20° -аас хэтэрдэггүй.

1.2.3. Гадаргын ус

Жалга, хөндийн өргөн нь 50-100 м, зарим үедээ 200-300 м хүрэх боловч сайрын эхэн хэсэгт 10-20 м байх ба түүнээс ч нарийн болсон байна. Жалга хөндий нь ерөнхийдөө нэлээн урт бөгөөд зарим томоохон сайрууд нь 20-30 км урт байх нь элбэг. Зарим хөндийд нь жижиг гол горхи урсдаг. Эдгээр жалга, хөндийгөөр урссан түр зуурын ус талбайн өмнө хэсэгт орших томоохон хөндийд очиж жижиг нуур, тойрмуудыг үүсгэдэг. Эдгээрээс хамгийн том нь Бигэр нуур юм. Хайгуулын талбай болон ойр орчмын нутагт ундны болон ахуйн усны гол хангалт нь худаг болон гадаргуугийн усан хангамж бүхий ил урсацтай усан сан юм. Худгууд нь ихэвчлэн ундарга багатай бөгөөд хамгийн их ундаргатай нь 1000 л/цаг хэмээн тэмдэглэгдсэн байна.

1.2.4. Гүний ус

Дөрөвдөгчийн пролювийн гаралтай нүх сүвийн ус агуулагч коллекторт агуулагдана. Нүх сүвийн коллектор нь сайр сайрга, дайр дайрга агуулсан элсэрхэг хурдсаас бүрдэнэ. Ус агуулагч давхарга нь 145 м хүртэл байрлах ба неогений ус үл нэвтрүүлэгч шаварлаг хурдсаар уллана. Уст давхаргын зузаан нь 21.4-66.0 м дунджаар 47.1 м байна. Ус нь судалгааны талбайн хэмжээнд гол төлөв сульфат-гидрокарбонат кальци-магнийн бүрэлдэхүүнтэй, сулавтар цэнгэг, 0.9-1.9 г/л эрдэсжилттэй. Ерөнхий хатуулаг нь 10.84 аас 24.08 мг-экв/л. Гидрогеохимийн агуулгаар кальци, магни, бичил элементээс хүнцэлийн агуулга нь унд-ахуйн хэрэглээний усанд тавигддаг MNS 900:2018 стандартын шаардлагад нийцэхгүй болно. 2019 онд Гранд Электро Техноком ХХК нь Ханбөөр, эрээн будагт алт, зэсийн ордын Хан-алтай төслийн баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн газрын доорх усны эрэл-хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн.

1.2.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс, уулын нимгэн хүрэн хөрс, уулын нугат хээрийн болон уулын нугын хөрс тархаж байна. 2019 оны 12-р сард хийсэн хөрсний дээжний шинжилгээнд Ni, Cu, Pb Zn, Cr нь MNS 5850:2019 хөрсний чанарын стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

1.2.6. Хур тунадас

Зундаа бороо бага орох бөгөөд өвөлдөө ч мөн цас бага унадаг гэсэн мэдээ бий, цасан бүрхүүл бараг байхгүй боловч зарим жилүүдэд 0.1-0.2 м хүрнэ. Жилийн хур тунадасны ихэнх нь зуны улиралд бороо хэлбэрээр ордог.

1.2.7. Ургамлын аймаг

Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос шалтгаалж ургамлын нягтшил багатай, их сийрэг тачир ургамал нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь шарилж, таана, мангир, хөмөл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, чихэр өвс, гоёо зэрэг эмийн ургамал, хайлаас, сухай, заг, бударгана, хармаг, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ.

1.2.8. Амьтны аймаг

Энд чоно, хярс, үнэг, өмхий хүрэн, мануул мэтийн махчин амьтад, хойлог, тас, харцага, элээ, ногтруу, тагтаа, болжмор, хулан жороо мэтийн жигүүртэн, гүрвэл, могой мэтийн хэвлээр явагч, туулай, алаг даага, бозлог мэтийн мэрэгчид, аалз, арваалж, ямаан ууц мэтийн шавж амьдардаг.

1.2.9. Тусгай хамгаалалттай газар нутаг

Тус төслийн нутаг дэвсгэр нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн тусгай хамгаалалтын газар нутагтай давхцалгүй байна. Харин төсөл хэрэгжих талбайн баруун захад Цахир Булаг нэртэй Аймгийн ОНТХГН байрлаж байна.

1.2.10. Нийгэм-эдийн засаг

Дүүрэг нутгийн хүрээнд хүн амын нягтрал маш бага бөгөөд талбайн ойр орчимд бараг айл нутагладаггүй. Талбайгаас 50 км зайд орших Бигэр сум дээр хүн эмнэлэг, сургууль, холбоо, банкны салбар, ШТС болон жижиг үйлчилгээний газруудтай. Тээврийн үндсэн төрөл нь автомашин, мотоцикл бөгөөд аймаг, сум, баг шороон замаар холбогддог. Хүн амын ихэнх нь халхууд бөгөөд хүн ам цөөтэй дийлэнх нь мал аж ахуй эрхэлдэг ба гар аргаар алт олборлогчид нэлээдгүй байдаг. Малын бүтцийн дийлэнх нь ямаа, хонь, тэмээ үлдсэн бага хувийг адуу, үхэр эзэлнэ. Харин ордоос баруун тийш 120 орчим км-т Цээл сумын нутагт орших “Алтайн хүдэр” ХХК-ийн Таян нуурын төмрийн хүдрийн уурхай ажилладаг бөгөөд уг уурхай нь Говь-Алтай аймгийн Алтай сумын нутагт орших Бургастайн хилийн боомт хүртэлх 168 км сайжруулсан технологийн замаас 50 км-т өндөр даацын зам тавьсан байна. Цаашид замаа үргэлжлүүлэн тавьж дуусгах төлөвлөгөөтэй байгаа зэрэг нь эдийн засгийн хувьд эерэг үзүүлэлт болж байна.

1.3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.3.1 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Уурхайн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 7. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1.	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн ашиглалтын 7 жилийн хугацаанд нийт 148.26 га талбай, 89.7 мян.м ³ үржил шимт хөрс үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх, бүрэн устах	Зайлиггүй				x	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2.	Үйлдвэрийн буцлах болон бөөнцөглөх хэсгээс агаарт тоосжилт үүсэх, улмаар цагаан уурын нөхцөл байдлаас шалтгаалан 50-250 м зайд тархах, орчныг бохирдуулах	Зайлиггүй					
		Боломжтой				x	
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
3.	Үйлдвэрийн технологийн үйл ажиллагаа нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг, ялангуяа үйлдвэрийг барьж байгуулах үед газрын гадарга, хөрс, түүний геологийн тогтоц, хэвлийд өөрчлөлт гарах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			x		
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
4.	Үйлдвэрийн талбайгаас эргэн тойрон 100 метр зайд хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгуй гарах зэргээр сөрөг нөлөөлөл бий	Зайлиггүй					
		Боломжтой		x			
		Магадгүй					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	болох	Магадлал муутай					
		Ховор					
5.	Нөлөөллийн хүрээнээс гадагш 200 метр дотор хүний үйл ажиллагаа, машин техникийн нөлөөлөл үүсэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		х			
		Ховор					
6.	Үйлдвэрийн ашиглалтын талбай орчмын ургамал талхгдах, хөрс хуулалтын улмаас үйлдвэрийн талбай орчмын ургамлан нөмрөг бүрэн устахын зэрэгцээ орчны талбайн ургамал, шимт хөрсний гадаад овоолгод түр хугацаанд дарагдах	Зайлиггүй					
		Боломжтой				х	
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
7.	Ашиглалтын жилүүдэд бэлчээрийн эдэлбэр газар багасаж, газрын өнгө төрх өөрчлөгдөх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
НИЙТ			2	2	3	-	
ЭЗЛЭХ ХУВЬ (%)			28.6	28.6	42.8	-	

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	ДҮГНЭЛТ	Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээг авч үзэхэд 57.2 % нь "Бага" болон "Дунд", 42.8 % нь "Их" гэсэн ангилалд хамрагдаж байгаа бөгөөд тохиолдох магадлалаар авч үзвэл 28.6 % нь тус бүр зайлиггүй болон боломжтой нөлөөлд хамрагдаж байна. Тиймээс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөллийг "Их" гэж дүгнэв. Учир нь төсөл хэрэгжүүлэх үе шатанд дээрх нөлөөллийг бууруулах юм уу арилгах аргагүй юм. Гэхдээ энэхүү нөлөөллийн хамрах хүрээ нь тухайн заасан хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд төсөл хэрэгжүүлэх явцад уг үйлдвэрийн техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөв. тул					

1.3.2 Уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв

Хүснэгт 8. Уур амьсгалын хүчин зүйлд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
1	Химийн бодисын хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих, халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөх, өндөр температур хэт халснаас тэсэрч, дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах.	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	x				
2	Шингэн төлөвтэй бодисууд дулааны нөлөөгөөр тэлэх, улмаар хальж асгарах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	x				

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
3	Хадгалах температурын өөрчлөлт, хэт их халалтаас шалтгаалан найрлага шинж чанарт өөрчлөлт орох	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
4	Аянга цахилгаан, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
НИЙТ			4	-	-	-	-
ЭЗЛЭХ ХУВЬ (%)			100	-	-	-	-
ДУГНЭЛТ		Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтаас уур амьсгалд үзүүлэх нөлөөлөл нь 100 % маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд харин тохиолдох магадлал нь ховор гэсэн ангилалд хамрагдаж байна. Цаг уур, уур амьсгалд үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, ялангуяа Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болзошгүй осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан тохиолдолд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.					

1.3.3 Агаарын чанарт үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл

Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9. Агаарын чанарт үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Үйлдвэрийн барилгын ажлын үед хөрс хуулах, тээвэрлэх болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртсөн ухмал, овоолгын талбайгаас ашиглалтын нийт хугацаанд тоосжилт үүсэх.	Зайлиггүй				x	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх хамгийн гол агаар бохирдуулагч бодисын орон зайн тархалтын үр дүнгээс үзэхэд нийт тоосонцор буюу TSP хамгийн ихдээ ялангуяа үйлдвэрийн дотоод тээврийн замын бүсэд 200-340 мкг/м ³ буюу Монгол улсын гадаад орчны MNS 4585:2016 стандартын жилийн ЗДХ болох 100 мкг/м ³ агууламжаас 2-3 дахин давж болзошгүй байна. PM10 тоосонцор үйлдвэр орчим мөн адил хамгийн их агууламж 60-110 мкг/м ³ хуртэлх агууламжтайгаар стандартын жилийн дундаж ЗДХ болох 50 мкг/м ³ агууламжаас 1-2 дахин давж байгаа нь үйлдвэрийн ажиллагсдад сөргөөр нөлөөлж болзошгүй байна.	Зайлиггүй					
		Боломжтой			x		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
3	Химийн бодисын агуулахад химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, агуулахын шал, гадаад орчинд асгарсанаас ажлын байрны орчны	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	агаарт нөлөөлөх	Магадлал муутай			■	■	■
		Ховор	х		■	■	■
4	Химийн хорт болон аюултай бодис агуулж байгаа сав нь хэт удаан хадгалах, нарны гэрэл тусах, хөлдөх, халах, зэврэх, урвалд орох зэргээс эвдрэх, цоорох, зөөлрөх зэрэг гэмтлээс шалтгаалан асгарч алдагдах, ажлын байрны агаарт тархах	Зайлиггүй	■	■	■	■	■
		Боломжтой	■	■	■	■	■
		Магадгүй		■	■	■	■
		Магадлал муутай		х	■	■	■
		Ховор			■	■	■
5	Химийн хортой болон аюултай бодисыг гадна талбайд ил задгай хаяснаас агаарт тэсрэмтгий хольц үүсгэх, гадаад орчинд агаарын урсгалаар дамжин нөлөөлөх	Зайлиггүй	■	■	■	■	■
		Боломжтой	■	■	■	■	■
		Магадгүй		■	х	■	■
		Магадлал муутай			■	■	■
		Ховор			■	■	■
6	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршиж, дэгдэмхий бодисууд агаарт уурих, исэлдэн урвалдах зэргээр агаарын чанар найрлагад нөлөөлөх	Зайлиггүй	■	■	■	■	■
		Боломжтой	■	■	■	■	■
		Магадгүй		■	■	■	■
		Магадлал муутай			■	■	■
		Ховор	х		■	■	■
7	Химийн бодистой шатах, гал авалцах эх үүсвэрийг ойр байлгаснаар гал түймэр гарах, тэсэрч дэлбэрснээр хортой хий ялгаран агаарын чанар, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Зайлиггүй	■	■	■	■	■
		Боломжтой	■	■	■	■	■
		Магадгүй		■	■	■	■
		Магадлал муутай			■	■	■
		Ховор	х		■	■	■
8	Тухайн бодисыг хадгалах үед хор	Зайлиггүй	■	■	■	■	■

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	аюулын лавлах мэдээлэлд заасан хадгалах нөхцөлийг хангасан орчныг агуулахад бүрдүүлээгүйгээс агаарын найрлага өөрчлөгдөх, улмаар хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Боломжтой		х			
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
	НИЙТ		3	2	2	1	-
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		37.5	25.0	25.0	12.5	-
	ДҮГНЭЛТ	Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн 75 % бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор нөлөөллийн ангилалд 37.5% нь хамрагдсан байна. Нөлөөллийн эрчим цар хүрээгээр нь авч үзвэл дунд болон их нөлөөлөл мөн 37.5%-ийг эзэлж байгаа бол, тохиолдох магадлалаар нь авч үзвэл зайлигүй болон боломжтой нөлөөлөл ихэнх хувийг эзэлж байгааг харгалзан төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөллийн -Дунд гэж дүгнэв.					

1.3.4 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Уурхайн бэлтгэл ажил.

Хан-Алтайн алтны үндсэн ордыг ашиглах уурхайн бэлтгэл ажил олборлолтын эхний жилд шимт хөрс хуулах, зам засах, хүдрийн овоолго болон хөрсний овоолгын талбай бэлдэх, баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн суурь бэлтгэх ажлууд хийгдэнэ. Уурхайн үндсэн болон туслах тоног төхөөрөмжийг ашиглан эдгээр ажлыг гүйцэтгэнэ. Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанд нийт хугацаанд 148.26 га талбай элэгдэл эвдрэлд өртөхөөр байна.

Уурхайн гадаад болон дотоод зам.

Уурхайгаас хөрсний 1, 2-р овоолго болон хүдрийн түр овоолго, баяжуулах үйлдвэр хүртэл сайжруулсан шороон зам тавигдана. Уурхайн замын уулзваруудыг өргөтгөх, зам бэлтгэх ажлыг гүйцэтгэхэд 120.8 мян.м3 газар шорооны ажил хийгдэнэ.

Шимт хөрсний овоолго.

Боловсруулах үйлдвэрийг ашиглах үйл ажиллагаанд нийт хугацаанд 148.26 га талбай элэгдэл эвдрэлд өртөхөөр байна. Төсөл хэрэгжих талбайн газрын гадарга нь өндөр уулын бүсэд хамаарах бөгөөд чулуу их, өнгөн хөрсний давхарга маш нимгэн, хүчтэй угаагдалд орсон байна. Тиймээс “Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5916:2008 стандартын 5.6 дахь хэсэгт “Дайргархаг, хайргархаг, чулуурхаг бүтэцтэй ба хүчтэй угаагдсан хөрсөнд шимт үеийг хуулах норм тогтоохгүй” гэж заасны дагуу үржил шимт хөрсийг 0.05-0.07 см-ээр хуулахаар төлөвлөв. Төслийн үйл ажиллагаанаас 148.26 га талбай элэгдэл, эвдрэлд өртөх бөгөөд үржил шимт хөрсийг 0.05 см, сийрэгжилтийн коэффициентийг 1.21-ээр тооцон MNS 5916:2008 стандартын дагуу 89.7 мян.м3 шимт хөрсийг хуулж, хадгалахаар төлөвлөв.

Хүдрийн овоолго.

Хүдрийн түр овоолгыг хүдрийн овоолго болон бага агуулгатай хүдрийн овоолго гэж ялган хураана. Ил уурхайн дэргэдэх хүдрийн түр овоолго нь баяжуулах үйлдвэрийг 14 хоног хангах нөөцийг хадгалах багтаамжтай байна. Хүдрийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдрийн агуулах хүртэл 7.7 км тээвэрлэнэ. Баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдэр ба бага агуулгатай хүдрийн агуулах руу нийт уулын ажлаар 10,107.03 мян.тн хүдэр олборлоно. Үүнээс хүдэр 7,978.9 мян.тн, бага агуулгатай хүдэр 2,128.07 мян.тн байна. Ашиглалтын 2 дахь жилээс баяжуулах үйлдвэр ажиллаж эхлэх учраас баяжуулах үйлдвэрийн дэргэд ашиглалтын 1 дэх жилээс 575.6 мян. м3 багтаамжтай хүдрийн түр агуулах үүснэ.

Хүснэгт 10. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах

№	Нөлөөллүүд	Нөлөөллий эрчим, цар хүрээТохиолдохм агадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн ашиглалтын 7 жилийн хугацаанд нийт 148.26 га талбай, 89.7	Зайлшгүй				х	
		Боломжтой					
		Магадгүй					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийг эрчим, цар хүрээТохиролдохм агадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	мян.м ³ үржил шимт хөрс үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх, бүрэн устах	Магадлал муутай					
		Ховор					
2	Үржил шимт хөрсний овоолго, хөрсний гадаад овоолго, чанарын бус хүдрийн овоолгод ашиглалтын 7 жилийн хугацаанд газрын гадаргад 10 м өндөртэй, 48.31 га талбайг эзэлсэн овоолго бий болж хөрсөн бүрхэвчийг дарах	Зайлигүй				х	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
3	Барилга байгууламжууд (үйлдвэрийн болон дэд бүтцийн), технологийн зам талбай, шугам шуудуу, цахилгааны дэд станц, усны өргөх станц, цэвэр ба үерийн усны сан зэрэг дэд бүтцэд ашиглагдах газруудад үүсэх хөрсөн бүрхэвчийн эвдрэл	Зайлигүй					
		Боломжтой			х		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
4	Үйлдвэрийг барьж байгуулах үеийн болон ашиглалтын үеийн ердийн хөрсөн замын нөлөөгөөр үүсэх өнгөн хөрсний талхагдал	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
5	Шинээр ашиглагдах газруудын шимт хөрсний хуулалт, тээвэрлэлт, хадгалалтын явцад үүсэх хөрсний бүтцийн алдрал	Зайлигүй					
		Боломжтой			х		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийг эрчим, цар хүрээТохиолдохм агадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
6	Анхдагч хүдэр боловсруулах үед буюу бутлах шигших үед ялгарах тоосжилтоос ердийн өнгөн хөрсөнд үзүүлж болзошгүй хүнд металлын бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй		х			
		Магадлал муутай					
		Ховор					
7	Нуруулдан уусгах талбай, химийн бодисын агуулах, баяжуулах үйлдвэрийн байгууламжууд, хаягдал хадгалах талбай зэрэг хорттой химийн бодис урвалж ашигладаг объектуудаас үүсэх болзошгүй химийн бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		х			
		Ховор					
8	Техник тоног төхөөрөмжийн эвдрэлээс болон тос тослох материалын агуулах савнаас тос, масло алдагдах болзошгүй органик бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		х			
9	Ахуйн болон хунсний гаралтай хатуу шингэн хог хаягдлаас үүсэх болзошгүй механик болон нянгийн бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй		х			
		Магадлал муутай					
		Ховор					
10	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөл т, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтыг горим алдагдсанаар	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх	Ховор	х				
11	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
12	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
НИЙТ			3	4	3	2	-
ЭЗЛЭХ ХУВЬ (%)			25.0	33.3	25.0	16.7	-
	ДҮГНЭЛТ	Төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийн 58.3% нь бага, маш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор болон магадлалтай, боломжтой ангилалд 66.6% нь хамрагдсан байна. Мөн нөлөөллийн эрчим цар хүрээгээр нь авч үзвэл дунд болон их нөлөөлөл 41.7 %-ийг эзэлж байгаа бол, тохиолдох магадлалаар нь авч үзвэл зайлигүй болон боломжтой нөлөөлөл ихэнх хувийг эзэлж байгааг харгалзан төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөллийг "Их" гэж дүгнэв. Нөлөөллийн үнэлгээнд хамрагдсан гол нөлөөллийг буруулах юм уу арилгах боломжгүй, зайлигүй тохиолдох нөлөөлөл тул "Их" гэсэн ангилалд хамруулав.					

1.3.5 Гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11. Гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохiolдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Төслийн ус хангамжийн цооног байрлах газрын доорх усны нөөц хомсдох	Зайлигүй					
		Боломжтой			x		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2	Төслийн талбайн газрын доорх усыг их хэмжээгээр татан авах нөхцөлд газрын доорх усны түвшин, урсцын чиглэлд өөрчлөлт гарах	Зайлигүй					
		Боломжтой			x		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
3	Хаягдлын сангийн усан дахь бохируулагч бодисоор газрын доорх ус бохирдох, шүүрэл үүсэх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		x			
4	Химийн бодисын хэрэглээ, шатах тослох материалыг газрын гадарга, хөрсөн бүрхэвчид алдсанаар хөрсөн бүрхэвч, ургамал нөмрөг бохирдож, улмаар агаарын хур тунадасны	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	угаагдлаар бага гүний ус бохирдох	Ховор		х			
5	Унд-ахуйн усны эх үүсвэр болох гүний худагт ариун цэврийн болон хамгаалалтын бүс тогтоогоогүйгээс бохирдох	Зайлиггүй					
		Боломжтой			х		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
6	Үер усны аюул, байгалийн гамигсаас шалтгаалан хаягдлын сан, нуруулдан уусгалтын талбайн үерийн усны далан сэтрэх, ханийн бэхлэгээ нурснаас бохир ус алдагдаж гадаргын болон гүний усыг бохирдуулах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
7	Тээвэрлэх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг түр урсцын голдирлуудад асгах, талбайд татан ирэх явцад бохирдлын эх үүсвэрийг бий болгох	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
8	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдоос үүдэн газрын гадаргад химийн бодис алдагдах, улмаар түүний урсцаар тархаж, голдирлын дагуух усыг бохирдуулах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		х			
	Усан орчинд урт болон богино хугацааны хурц хоруу чанартай, усны амьд организмд хортой	Зайлиггүй					
		Боломжтой					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
9	зэрэглэлд хамаарах бодисын хадгалалт, ашиглалтыг зохих журмын дагуу явуулаагүйгээс усан орчинд сөрөг нөлөөлөх	Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
10	Ахуйн бохир усыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, бохир ус хадгалах сан байгуулаагүйгээс хөрсөнд хаягдаж бохирдол үүсгэх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		х			
		Ховор					
	НИЙТ		-4	-4	-3		
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		36.4	36.4	27.3		
	ДҮГНЭЛТ	Төслөөс гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээгээр авч үзэхэд 72.8 % нь бага, маш бага буюу нөлөөгүй, тохиолдох магадлалаар нь авч үзвэл ховор болон магадлал муутай нөлөөлөл 81.8%-ийг тус тус эзэлж байна. Харин нөлөөллийн эрчим, цар хүрээгээр дунд ангилалд 27.3 %-ийг эзэлж байгааг харгалзан усан орчинд үзүүлэх нөлөөллийг "Бага" гэж дүгнэв.					

1.3.6 Ургамлан бүрхэвчинд үзүүлэх гол болон сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслийн зайлшгүй үйл ажиллагаатай холбоотойгоор уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын ургамлан бүрхэвчийг устгаснаас үүдэх дам сөрөг нөлөөллүүд нь хөрс эвдрэлд өртөмхий болох, хөрсний сул шороо агаарт дэгдэж агаар дахь тоосжилтыг нэмэгдүүлэх, улмаар энэ нь эргээд ургамлын ургах нөхцөл болон хүрээлэн буй орчинд шууд болон дам хэлбэрээр нөлөөлж болзошгүй юм.

Уурхайн үйл ажиллагааг явуулах үед орчны ургамлан бүрхэвчинд доор дурдсан сөрөг нөлөөллүүд учирч болзошгүй байна. Үүнд:

Хүснэгт 12. Ургамлан бүрхэвчинд үзүүлэх гол болон сөрөг нөлөөлөл, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн орчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэрийн ашиглалтын 7 жилийн хугацаанд нийт 148.26 га талбай, 89.7 мян.м ³ үржил шимт хөрс, ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх, бүрэн устгах	Зайлигүй				x	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2	Үржил шимт хөрсний овоолго, хөрсний гадаад овоолго, чанарын бус хүдрийн овоолгод ашиглалтын 7 жилийн хугацаанд Газрын гадаргад 10 м өндөртэй, 48.31 га талбайг эзэлсэн овоолго бий болж ургамлан нөмрөг дарагдах	Зайлигүй				x	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
3	Нуруулдан уусгах талбай, химийн бодисын агуулах, баяжуулах үйлдвэрийн байгууламжууд, хаягдал хадгалах талбай зэрэг хорттой химийн бодис урвалж ашигладаг объектуудаас үүсэх болзошгүй химийн бохирдлын	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй			x		
		Магадлал муутай					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн орчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	сөрөг нөлөөлөл	Ховор					
4	Техник тоног төхөөрөмжийн эвдрэлээс болон тос тослох материалын агуулах савнаас тос, масло алдагдах болзошгүй органик бохирдлын сөрөг нөлөөлөл	Зайлигуй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
5	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтыг горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл	Зайлигуй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай	х				
		Ховор					
6	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, ургамлан нөмрөгт нөлөөлөл	Зайлигуй					
		Боломжтой					
		Магадгүй	х				
		Магадлал муутай					
		Ховор					
7	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биет, ургамлан нөмрөгт дам нөлөөлөл	Зайлигуй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
	Ургамлан бүрхэвчийг устгаснаас үүдэх дам сөрөг нөлөөллүүд нь хөрс эвдрэлд өртөмхий болох,	Зайлигуй					
		Боломжтой					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн орчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
8	хөрсний сул шороо агаарт дэгдэж агаарын тоосжилтыг нэмэгдүүлэх, улмаар энэ нь эргээд ургамал болон байгаль орчинд шууд болон дам хэлбэрээр нөлөөлөх	Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		х			
9	Ургамлан нөмрөгийн фотосинтезийн идэвх буурах, өсөлт удааширах улмаар өсөлт нь бүрмөсөн зогсож ургахаа болих	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
10	Үйлдвэр ашиглалтын үед замын маршрут тогтоогоогүйгээс замбараагүй олон салаа зам гарах, ургамлан нөмрөг талхлагдах	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
11	Үйлдвэрийн талбайн нөлөөллийн бүсийн эргэн тойрон 100 метр зайд хөрс, ургамал халцрах болон талхлагдах, зам харгүй гарах зэргээр сөрөг нөлөөлөл бий болох	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай	х				
		Ховор					
12	Нөлөөллийн хүрээнээс гадагш 200 метр дотор хүний үйл ажиллагаа, машин техникийн нөлөөлөл үүсэх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй	х				
		Магадлал муутай					
		Ховор					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн орчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
13	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас техник технологийн гэнэтийн эвдрэл гэмтэл болон ажилчдын санаандгүй алдаанаас хөрс шатах тослох материалаар бохирдох, улмаар ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
НИЙТ			-4	-1	-1	-2	
ЭЗЛЭХ ХУВЬ (%)			50.0	12.5	12.5	25.0	
	ДҮГНЭЛТ	Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээг авч үзэхэд 62.5 % нь бага, бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар авч үзвэл 37.5 % нь ховор тохиолдох, магадлалтай байна. Харин “Дунд болон Их” гэсэн ангилал 37.5% нь хамрагдаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед ашиглагдах талбайн ургамлан нөмрөг бүрэн устах, нөлөөлд хүчтэй өртөхөөр байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл зайлигүй ангилалд хамрагдаж байна. Учир нь төсөл хэрэгжүүлэх үе шатанд дээрх нөлөөллийг бууруулах юм уу арилгах аргагүй юм. Гэхдээ энэхүү нөлөөллийн хамрах хүрээ нь тухайн заасан хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд төсөл хэрэгжүүлэх явцад ашиглагдсан талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх тул нөлөөллийг бууруулах боломжтой байна.					

1.3.7 Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Төслийн бүтээн байгуулалтын явцад уурхайн зөвшөөрөл бүхий талбайд ан амьтны амьдрах орчин алдагдана. Төслийн зүгээс амьтны аймагт сөрөг нөлөөлөл учруулж болохуйц газар нь уурхайн зөвшөөрөл бүхий талбай болох бөгөөд энэ нь тус бүс нутгийн биологи газарзүйн бүсийн нийт хэмжээтэй харьцуулахад маш бага талбай юм. Бүтээн байгуулалт болон уурхайн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл нь тэсэлгээ, дуу чимээ, гэрэл чийдэн болон машин техникийн хөдөлгөөн зэрэг хүчин зүйлүүд байх бөгөөд төслийн бүс нутгийн ойролцоо зэрлэг ан амьтныг үргээж, энэ орчимд байрших амьтдын тоог бууруулж болзошгүй. Мөн тухайн орчинд ажиллаж, амьдрах хүний тоо нэмэгдсэнээр ан агнуур хийх явдал ихсэж, ан амьтанд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй.

Хүснэгт 13. Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюулт ай
ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
1	Исэлдсэн болон анхдагч хүдэр боловсруулах үйлдвэр, түүнийг дагасан үндсэн болон туслах барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалт, газар шорооны ажлын үед мэрэгч болон мөлхөгч амьтдын амьдрах орчин устаж үгүй болох, тоо толгой цөөрөх	Зайлишгүй				х	
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
2	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед тухайн орчны сээр нуруугүйтэн амьтдын амьдрах орчныг хязгаарлаж, тоо толгойг цөөрүүлэх	Зайлишгүй				х	
		Боломжтой				х	
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
3	Үйлдвэр, уурхайн тээвэрлэлтийн үед ашиглах хүнд даацын машин механизм, автомашинуудын хөдөлгөөнөөс үүсэх дуу чимээ, гэрэл, хорт утаа, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэн бий болох тоосжилт зэргээс үүдэн тухайн ажил явагдаж байгаа	Зайлишгүй				х	
		Боломжтой				х	
		Магадгүй					
		Магадлал муутай					

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	газрын ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах	Ховор					
БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ							
4	Аливаа нэгэн зүйл устаж, дайжиж алга болсонтой холбоотойгоор экологийн идэш тэжээлийн харилцаа холбоо алдагдах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор		х			
5	Тухайн нутагт нутагладаг зэрлэг амьтад болон мал үйлдвэрийн ухааш, шуудуунд унаж бэртэх, хорогдох	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
6	Агнуурын ач холбогдолтой, ховордож буй болон улаан номд орсон төрөл зүйлийг үйлдвэрийн ажилчид хулгайгаар агнах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
НИЙТ			-2	-1	-2	-1	-
ЭЗЛЭХ ХУВЬ (%)			33.3	16.7	33.3	16.7	-

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюулт ай
	ДҮГНЭЛТ	Төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээг авч үзэхэд 50 % нь бага, бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалаар авч үзвэл 33.3 % нь ховор тохиолдох магадлалтай байна. Мөн -Дунд болон Их гэсэн ангилал 50% нь хамрагдаж байгаа бөгөөд үйлдвэрийн үйл ажиллагаа, дэд бүтэцтэй холбогдон ан амьтны байршил нутаг алдагдах, чимээ шуугиан, гэрлийн нөлөөгөөр ан амьтан үргэх, дайжих нөлөөлөх байдлын үнэлгээг “ДУНД” гэж дүгнэв.					

1.3.8 Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд учруулах гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Хан Алтайн алтны үндсэн ордын Боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийг нэгтгэн авч үзье. Үүнд:

- Үйлдвэрийн үндсэн болон туслах барилга байгууламжийн хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах.
- Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.
- Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бус орчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хадгалах үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнтэй харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах.
- Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн нь хэвийн нөхцөлд тогтвортой боловч өндөр температурт шатах, хүчтэй хүчлүүдтэй урвалд орвол аюултай бодис тул харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс асарч алдагдах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх зэрэг болно.

Хүснэгт 14. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдал, үнэлгээ

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
1	Үйлдвэрийн үндсэн болон туслах барилга байгууламжийн хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдоос үүдэн аюул, осол гарах	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
2	Мэргэжилтэн, ажилтны чадваргүй байдал, хариуцлагагүй үйлдэл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай		х			
		Ховор					
3	Үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
4	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хамт хадгалж болохгүй бодис болон зориулалтын бусорчин, агуулахад хадгалснаас хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Зайлигүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
5	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнийг хадгалах үйл ажиллагаа нь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбай, ослын үед ажиллах арга хэмжээний төлөвлөгөөгүй ажилласнаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд хохирол үүсэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
6	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнтэй харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох	Зайлиггүй					
		Боломжтой			х		
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор					
7	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байриуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй			х		
		Магадлал муутай					
		Ховор					
8	Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн нь хэвийн нөхцөлд тогтвортой боловч өндөр температурт шатах, хүчтэй хүчлүүдтэй урвалд орвол аюултай бодис тул харьцах үедээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс асгарч алдагдах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөл үзүүлэх	Зайлиггүй					
		Боломжтой					
		Магадгүй					
		Магадлал муутай					
		Ховор	х				
НИЙТ			4	1	3		

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн эрчим, цар хүрээ Тохиолдох магадлал	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
			Мааш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц Аюултай
	ЭЗЛЭХ ХУВЬ (%)		50	12.5	37.5		
	ДҮГНЭЛТ	<p>Аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн 62.5% нь бага, мааш бага буюу нөлөөгүй байгаа бөгөөд тохиолдох магадлалын 50% нь ховор тохиолдохоор байна. Харин нийт нөлөөллийн 37.5% нь нөлөөллийн эрчим цар хүрээгээр дунд гэсэн ангилалд орж байгаа бөгөөд тохиолдох магадлалаар нь авч үзвэл магадгүй болон боломжтой ангилалд орж байна. Учир нь тус байгууллага нь үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүн хадгалах үйл ажиллагааг нэг бүрээр боловсруулж мөрдөөгүйгээс аюулгүй байдал алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх, аюултай хог хаягдал, шатах тослох материал, эсвэл химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүнтэй харьцаж ажиллах ажиллагсад нь зохих шатны сургалтад хамрагдаагүй, зохих мэдлэг дадлыг эзэмшээгүйгээс химийн бодистой харьцаж ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зөрчих, хордох, химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд заасан болзошгүй аюул, ослын үед ашиглах багаж хэрэгсэл, материалыг ажлын байранд байршуулж, ажиллагсад ажиллах дадлыг эзэмшүүлээгүйгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учрах эрсдэлтэй байгаа тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах шаардлагатай. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан тохиолдолд химийн бодисын хадгалалтаас хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх боломжтой байна.</p>					

1.4 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

1.4.1. Байгаль хамгаалах ажлын зорилго, зорилт:

Хан Алтай төслийн 2023 оны байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөг 2022 онд Грийн Ассесмент ХХК-ийн боловсруулсан “Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутаг орших “Хан Алтай Ресурс” ХХК-ийн MV-021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хан-Алтайн алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах, исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн төсөл”-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд тус төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг зорилго болгосон.

1.4.2. Хамрах хүрээ:

Хан Алтай төслийн MV-021537 лицензийн талбайд явагдаж байгаа барилгын ажил, үндсэн олборлолтын үйл ажиллагаас гадна дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой бүхий л үйл ажиллагаанд хамаарна.

БҮЛЭГ ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2-1. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх боломжтой дулааны улиралд усалгааг байнга хийх, хуваарь гаргах	Төслийн талбайн дотоод зам, шаардлагатай бүх зам	Тогтмол хэрэгжүүлж байна	Төслийн талбайн нийт замын сүлжээг боловсруулан баталсан бөгөөд тухайн батлагдсан маршрутыг хөдөлгөөнт техник бүрд байрлуулсан. Тухайн нэгдсэн замын трассын дагуу хөдөлгөөнт тээврийн замуудад өдөр, шөнийн ээлжинд усалгааг усны машинаар тогтмол хийж гүйцэтгэсэн. Одоогоор төслийн талбайд үндсэн болон гэрээт компанийн нийт 20 тонны багтаамж бүхий 3 30 тонны багтаамж бүхий 1 тээврийн хэрэгсэл усалгааны хуваарийн дагуу ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг энэ бүлгийн 2.1.1 хэсгээс танилцана уу.
№	Бариа материал, эд зүйлийн нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Жин	Чанар байдал
1					
2					
5					
6					
7					
Лая					

Ачаа өчих үеийн

Хүлээлгэн өгсөн:

Утас:

Хүлээн авсан:

Утас:

Огноо:

Ачаа буулгах үеийн

Хүлээн авсан:

Утас:

Хүлээлгэн өгсөн:


Утас:

Огноо:

БАТАЛГААЖУУЛСАН:


ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гэрээ, хангамжийн менежер

 С.Очүү

ТЭЭВЭРЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

Гүйцэтгэх захирал

 Г.Батмөнх

10

Зураг 39. Химийн бодисын тээврийн гэрээ

2.4. Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2-4. Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлтийн биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1		Нүүрсний талбайг хайргажуулах, хашаа хамгаалалт хийх газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Уурын зуух орчим	Төлөвлөж байгаа	Баяжуулах үйлдвэр болон уурхайн суурингийн халаалтын зуухны Нүүрсний талбайг хайргажуулах, хашаа хамгаалалт хийх, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд тусгайлан цементэлсэн талбайд 2 таславчтай бетонон ханан байгууламж барьж байгуулах ажлыг төлөвлөн ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.4.1 хэсгээс танилцана уу
2	Газрын гадарга, хэвлийн эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхийн өмнө “Газар хөндөх зөвшөөрөл”-ийг өгөх	Ил уурхай, барилгын ажлын бэлтгэл ажлын хүрээнд	Тогтмол хэрэгжүүлж байна	Хан Алтай төслийн газар хөндөх зөвшөөрлийг дараах хэсгүүдэд өгч ажилласан. Үүнд: Уурхайн олборлолтод шинэ газар хөндөхөд, өрөм хайгуулын үйл ажиллагаанд шинээр хайгуулын өрмийн зам тавих, төслийн дотоод орчинд шинээр технологийн тээврийн зам тавих, шинээр барилга байгууламж барьж байгуулах, ус сувгийн шугам хоолой шинээр тавих, шинээр нийтийн бие засах гадаад орчны цэг байгуулах, шилэн кабель татах, зэрэгт газар хөндөх зөвшөөрөл болон зөвлөмжийг өгч ажиллалаа. 2023 онд 8 газар 57,600м ² 5.7га талбайд хөндөх зөвшөөрлийг олгож 3,202м ³ шимт хөрс хуулсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.4.2 хэсгээс танилцана уу.

3		<p>Зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэж, зөрчлийг арилгах, шаардлагатай арга хэмжээг авах</p>	<p>Төслийн үйл ажиллагааны хүрээнд</p>	<p>Тогтмол хэрэгжүүлж байна</p>	<p>2023 онд зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд аливаа барилга угсралтын ажил, уурхайн ахилт, олборлолтын ажил, хайгуул өрөмдлөгийн ажил болон бусад газар хөндөх, ухалт малталттай холбоотой бүхий л ажлуудад холбогдох газар хөндөх зөвшөөрлийг өгч ажилласан. 2023 онд 8 газар 57,600м² 5.7га талбайд хөндөх зөвшөөрлийг олгож 3,202м³ шимт хөрс хуулсан байна.</p>

2.4. Газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй

2.4.1. Нүүрсний талбайг хайргажуулах, хашаа хамгаалалт хийх газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Баяжуулах үйлдвэр болон уурхайн суурингийн халаалтын зуухны Нүүрсний талбайг хайргажуулах, хашаа хамгаалалт хийх, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд тусгайлан цементэлсэн талбайд 2 таславчтай бетонон ханан байгууламж барьж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



Зураг 40. Төлөвлөж буй нүүрсний талбайн ерөнхий зураг

2.4.2. Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх ажлыг эхлүүлэхийн өмнө “Газар хөндөх зөвшөөрөл”-ийг өгөх


Хан Алтай төслийн газар хөндөх зөвшөөрлийг дараах хэсгүүдэд өгч ажилласан. Үүнд:

Уурхайн олборлолтод шинэ газар хөндөхөд, өрөм хайгуулын үйл ажиллагаанд шинээр хайгуулын өрмийн зам тавих, төслийн дотоод орчинд шинээр технологийн тээврийн зам тавих, шинээр барилга байгууламж барьж байгуулах, ус сувгийн шугам хоолой шинээр тавих, шинээр нийтийн бие засах гадаад орчны цэг байгуулах, шилэн кабель татах, зэрэгт газар хөндөх зөвшөөрөл болон зөвлөмжийг өгч ажиллалаа. 2023 онд 8 газар 57,600м² 5.7га талбайд хөндөх зөвшөөрлийг олгож 3,202м³ шимт хөрс хуулсан байна.

Газар хөндөх, үржил шимт хөрс хуулах, хадгалах ажлын стандарт журмын хүрээнд аливаа ажил гүйцэтгэх гэж байгаа хэлтэс нэгж гэрээт компаниудад дараах 3 хавсралтын дагуу зөвшөөрөл олгож байна.

1. Газар хөндөх зөвшөөрлийн маягт Хавсралт. 01
2. Шимт хөрс бүртгэлийн хуудас Хавсралт. 02
3. Фото болон дэвсгэр зураг Хавсралт. 03

Газар хөндөх зөвшөөрөл олгохын өмнө байгаль орчны багаас ховор ургамлын бүлгэмдэл, шилжүүлэн суулгах шаардлагатай эсэх, мэрэгч амьтдын гол төлөөлөл, нөлөөллөх хүчин зүйл, түүх соёлын өвтэй холбогдох асуудал, шимт хөрсийг хэр зузаантай хуулах тооцоолол болон нэмэлт шаардлага зэргийг тодорхойлсон байдаг.



Зураг 41. Газар хөндөх зөвшөөрлийн маягтууд

Хүснэгт 16. Олгогдсон газар хөндөх зөвшөөрөл 2023 онд

№	Огноо	Газар хөндөх зөвшөөрөл	Талбай /м2/	Шимт хөрс /м3/
1	20230923	Ус хангамжийн системийн барилга	9000	90
2	20230922	Хөрсний овоолго байгуулах талбай	Шит хөрс хуулагдсан талбай	
3	20230809	Ашигласан тос тосолгооны материал талбай байгуулах		
4	20230618	Бохир усны шуудуу татах		
5	20230419	Улаан шавар тээвэрлэх түр зам гаргах	11000	220
6	20230331	Хацарт бутлуурын үйл ажиллагааны талбай бэлдэх	22800	2300
7	20230302	Уурхайн нэгдсэн агуулах барих талбай бэлдэх	5000	Хуулсан
8	20230302	Засвар механикийн цехийн барилга барих талбай бэлдэх	4700	592

2.4.3. Зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэж, зөрчлийг арилгах, шаардлагатай арга хэмжээг авах:

Тайлант онд уурхайн хэмжээнд зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдол бүртгэгдээгүй. Газар, газрын хэвлийд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөх зорилгоор “Хан Алтай ресурс” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн Т-71-А-23-67 дугаар “Газрын бодлого, төлөвлөлтийг боловсруулах” ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.

2.5. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2-5. Ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлтийн биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1		Замын хажуугаарх ургамлыг тоосжилтод өртөхөөс хамгаалж, замын арчилгааг хийснээр ургамалжилтад учруулах сөрөг нөлөөллийг хамгийн доод хэмжээнд байлгах, хучилтгүй зам дээр явах машины хурдыг хязгаарлах	Төслийн талбай, технологийн болон бусад зам	Тогтмол хэрэгжүүлж байна	Хан Алтай төслийн авто замын нэгдсэн сүлжээг төслийн бүтээн байгуулалттай уялдуулан, боловсруулсан бөгөөд батлагдсан нэгдсэн маршрутыг үндсэн гэрээт компанийн ажилчдад танилцуулан, төслийн талбайд ашиглагдаж буй хөдөлгөөнт техникүүдэд байрлуулсан. Уурхайн зам талбайн засвар үйлчилгээний баг зам хяналтын нэг жилийн хуваарь гаргаж төслийн болон орон нутгийн замуудад хувиарийн дагуу тойрох үзлэг хийж, засвар үйлчилгээг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.5.1 хэсгээс танилцана уу.
2		Уурхайн талбай орчмын ургамлан нөмрөг, төрөл зүйлийн нарийвчилсан судалгаа хийх	Уурхайн лицензийн талбай орчим	Бүрэн хэрэгжсэн	Тус ажлын хүрээнд Байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “ЭКО ЭСТИМЕЙТ” ХХК-р Ургамлын аймгийн нарийвчилсан судалгааг хийлгэсэн. Энэхүү судалгааны MV-021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 6793 га талбайн хүрээнд 32 овог, 85 төрлийн 127 зүйл ургамал тархсаныг тодорхойлноос гадна

					<p>зургаан томоохон бүлгэмдэл илрүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Олон наст өвслөг ургамал 86 зүйл 68% ✓ Нэг наст өвслөг ургамлууд 25 (20%), ✓ Сөөг, сөөгөнцөр ургамлууд 16 (12%) <p>Дэлгэрэнгүй мэдээллийг 2.5.2 хэсгээс танилцана уу.</p>
3		Цөлжилттэй тэмцэх үндэсний өдрийг орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Төрийн болон төрийн бус байгууллага	Бүрэн хэрэгжсэн	<p>Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран УЦУОШТөв, ЦУОШГазар, хүрээлэн, Биологийн олон янз, байдлыг хамгаалах уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь төсөл, Монголын унаган байдлын хүлцэл тогтворжилтыг хангах нь төсөл хамтран байгаль орчны салбарын байгууллагууд, 18 сумын удирдлага, холбогдох мэргэжилтэн албан хаагчдыг хамруулан “Аймгийн Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн байдал өнөөдрийн байдлаар ямар хэмжээнд хүрсэн байгаа талаар хийгдсэн судалгаа тайланг сонсож цаашид ямар ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх талаарх хэлэлцүүлгийг Жаргалан сумын “Хүнхэр амралтын газар”-т 2023 оны 06 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан.</p> <p>Дэлгэрэнгүй мэдээллийг 2.5.3 хэсгээс танилцана уу.</p>
4		Мод тарих үндэсний өдрийг 5,10 сард зохион байгуулж уурхайн ногоон байгууламжыг нэмэгдүүлэх	Уурхайн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	<p>“Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачилгын хүрээнд ГАА-ийн 108сая мод тарих аянд нэгдэн</p>

					Намрын “Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан төслийн талбайд 8 төрлийн 6740 ширхэг модыг тарьсан. Мөн ажилчдын хотхон “Өргөө кемпийн” ногоон байгууламжийг нэмэгдүүлж 842м2 талбайг зүлэгжүүлж арчилгаа усалгаа хийж ажиллаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.5.4 хэсгээс танилцана уу.
5		Шимт хөрсний налуу хэсэгт уурхай орчмын байгаль цаг уурт тохиромжтой олон наст үрийг тарьж ургамалжуулах	Шимт хөрсний овоолго	Төлөвлөж байна	Шимт хөрс хуулалтын ажил тогтмол хийгдэж байгаа бөгөөд хаагдсан шимт хөрсний овоолго байхгүй байна. Шимт хөрсний менежментийн төлөвлөгөөний дагуу овоолго хаагдмагц ургамалжуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
6		Орон нутгийн байгууллагтай хамтран уурхай орчмын ургамлын үр түүх, үрийн фонд үүсгэх	Уурхайн талбай орчим	Тогтмол хэрэгжүүлж байна	Говь-Алтай аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ЭКО клубийн хүүхдүүдтэй хамтарч Шар Хуайсын үр түүж үрийн фондыг нэмэгдүүлж хамтарч ажилласан. Мөн төслийн талбай орчмоос Харган, Хармагийн үр түүж цайруулж бэлтгэсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.5.5 хэсгээс танилцана уу.

2.5. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй

2.5.1. Замын хажуугаарх ургамлыг тоосжилтод өртөхөөс хамгаалж, замын арчилгааг хийснээр ургамалжилтад учруулах сөрөг нөлөөллийг хамгийн доод хэмжээнд байлгах, хучилтгүй зам дээр явах машины хурдыг хязгаарлах

Замын хажуугаарх ургамлыг тоосжилтод өртөхөөс хамгаалж, замын арчилгааг хийснээр ургамалжилтад учруулах сөрөг нөлөөллийг хамгийн доод хэмжээнд байлгах, хучилтгүй зам дээр явах машины хурдыг хязгаарлах Хүнд машин механизм болон хөнгөн тэрэгний хурдад хурдны хязгаарлалт тогтоож, үүсэх тоосны хэмжээг бууруулах зорилгоор төслийн талбайд хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн “Жолоодох эрхийн сургалт”-ыг “ Хүний нөөц” сургалтын хэлтсээс орж сургалтад сууж шалгалтад тэнцсэн ажилчдад төслийн талбайд жолоо барьж хөдөлгөөнд оролцох эрхийн үнэмлэхийг олгон ажиллаж байна.

Төслийн авто замын нэгдсэн сүлжээг төслийн бүтээн байгуулалттай уялдуулан, боловсруулсан бөгөөд батлагдсан нэгдсэн маршрутыг үндсэн гэрээт компанийн ажилчдад танилцуулан, төслийн талбайд ашиглагдаж буй хөдөлгөөнт техникүүдэд байрлуулсан. Уурхайн зам талбайн засвар үйлчилгээний баг зам хяналтын нэг жилийн хуваарь гаргаж төслийн болон орон нутгийн замуудад хувиарийн дагуу тойрох үзлэг хийж, засвар үйлчилгээг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.




Зураг 42. Хөнгөн тэрэгний сургалт, дромын талбайд шалгалт авч байгаа нь

2.5.2. Уурхайн талбай орчмын ургамлан нөмрөг, төрөл зүйлийн нарийвчилсан судалгаа хийх.

Тус ажлын хүрээнд Байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “ЭКО ЭСТИМЕЙТ” ХХК-р Ургамлын аймгийн нарийвчилсан судалгааг хийлгэсэн. Энэхүү судалгааны MV-021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 6793 га талбайн хүрээнд 32 овог, 85 төрлийн 127 зүйл ургамал тархсаныг тодорхойлноос гадна зургаан томоохон бүлгэмдэл илрүүлсэн.

- ✓ Олон наст өвслөг ургамал 86 зүйл 68%
- ✓ Нэг наст өвслөг ургамлууд 25 (20%),
- ✓ Сөөг, сөөгөнцөр ургамлууд 16 (12%)



Зураг 43. Ургамалын хээрийн судалгаа

2.5.3. Цөлжилттэй тэмцэх үндэсний өдрийг орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах

Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран УЦУОШТөв, ЦУОШГазар, хүрээлэн, Биологийн олон янз, байдлыг хамгаалах уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь төсөл, Монголын унаган байдлын хүлцэл тогтворжилтыг хангах нь төсөл хамтран байгаль орчны салбарын байгууллагууд, 18 сумын удирдлага, холбогдох мэргэжилтэн албан хаагчдыг хамруулан “Аймгийн Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн байдал өнөөдрийн байдлаар ямар хэмжээнд хүрсэн байгаа талаар хийгдсэн судалгаа тайланг сонсож цаашид ямар ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэх талаарх хэлэлцүүлгийг Жаргалан сумын “Хүнхэр амралтын газар”-т 2023 оны 06 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Тус хэлэлцүүлгээр Говь-Алтай аймгийн уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, цөлжилтийг сааруулах чиглэлээр судалгаанд суурилсан оновчтой төлөвлөлийг 2030 он хүртэл

хийж хэрэгжүүлэхээр талууд "Тунхаг бичиг" гарган байгаль орчны салбарын байгууллагууд, 18 сумын удирдлагууд гарын үсэг зурж баталгаажуулсан.



Зураг 44. Цөлжилттэй тэмцэх үндэсний өдөр

2.5.4. Мод тарих үндэсний өдрийг 5,10 сард зохион байгуулж уурхайн ногоон байгууламжыг нэмэгдүүлэх

“Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачилгын хүрээнд ГАА-ийн 108сая мод тарих аянд нэгдэн Намрын “Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан төслийн талбайд 8 төрлийн 6740 ширхэг модыг тарьсан.

Мод үржүүлгийн газарт тарьсан модны тоо, суулгацын төрөл:



График 2. Мод үржүүлгийн газарт ойн зурвас, их ургамлын талбай байгуулсан хэмжээ





График 3 Өргөө кемпийн орчим тарьсан модны хэмжээ



Зураг 45. Намрын мод тарилт төлөвлөлтийн зураг



Зураг 46. Намрын бүх нийтийн мод тарилт

Ажилчдын хотхон “Өргөө кемпийн” ногоон байгууламжийг нэмэгдүүлж 842м2 талбайг зүлэгжүүлж арчилгаа усалгаа хийж ажиллаж байна.



Зураг 47. Өргөө кемпийн ногоон байгууламж

2.5.5. Орон нутгийн байгууллагатай хамтран уурхай орчмын ургамлын үр түүх, үрийн фонд үүсгэх

Говь-Алтай аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ЭКО клубийн хүүхдүүдтэй хамтарч Шар Хуайсын үр түүж үрийн фондыг нэмэгдүүлж хамтарч ажилласан. Мөн төслийн талбай орчмоос Харган, Хармагийн үр түүж цайруулж бэлтгэсэн.

-Төслийн талбай орчмоос үр бэлтгэсэн:

- ✓ Харганы үр 3 кг орчмыг түүж цайруулсан.
- ✓ Хармагны үр 8 кг түүж цайруулсан



Зураг 48. Харган, Хармагны үр түүж байгаа байдал



Зураг 49. Харган, Хармагны үр түүж цайруулсан байдал

2.6. Амьтан аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2-6. Амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөлтийн биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Үйлдвэрийн химийн бодисын хэрэглээнээс шалтгаалан агаарт дэгдэн амьтдад нөлөөлөх	Орон нутагт ан хийхийг хориглох, галт зэвсэг хэрэгсэл байлгахыг хориглох талаар сурталчилах	Нөлөөллийн бүс	Тогтмол хэрэгжүүлж байна	Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйл Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн нийтлэг үүрэгтэй уялдуулан төслийн нөлөөллийн бүс болоод уурхайн бүхий л үйл ажиллагааны хүрээнд галт зэвсэг, амьтан баригч урхи, хавх ашиглахыг хориглодог бөгөөд галт зэвсэг ашиглах, ан хийхийг хориглох талаар мэдээллийг орон нутгийн иргэдэд сурталчилж ажилласан. Тайлант онд хууль бус ан агнуур 1 бүртгэгдсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.6.1 хэсгээс танилцана уу.
2		Тухайн нутагт нутагладаг зэрлэг амьтад болон мал үйлдвэрийн талбайд орох ухаш, шуудуунд унаж бэртэх, хорогдохоос урьдчилан сэргийлэх, нуруулдан	Уурхайн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Нуруулдан уусгах байгууламж, баяжуулах үйлдвэрийн хэсэгт зэрлэг амьтан нэвтрэхээс сэргийлж, тойруулан хашаажуулалт хийсэн. Түүнчлэн, жигүүртэн шувуунд нөлөөллөх сөрөг нөлөөллийг бууруулж 20 ширхэг Bird X Peller PRO шувуу үргэгчийг нуруулдан уусгах

		уусгалтын талбайд шувуу үргээгч байрлуулах			байгууламжийн далан, хөмсөгт байрлуулж өгсөн.
3		Нуруулдан уусгах байгууламж, баяжуулах үйлдвэрийн хэсэгт ан амьтан орохоос сэргийлж хашаажуулах	Төслийн талбай	Тогтмол хэрэгжүүлж байна	Дэлгэрэнгүй мэдээллийг 2.6.2 хэсгээс танилцана уу.
4		Орон нутгийн байгууллагуудтай хамтран зэрлэг ан амьтанд өвөл, хаврын үед биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Говь-Алтай аймаг	Бүрэн хэрэгжсэн	Амьтны амьдрах орчин, идэш тэжээлийн нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор төслийн ургамал, амьтны судалгаанд үндэслэн Янгир ямаа нутагладаг 4 цэгт 50 пресс өвс тавьж өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.6.4 хэсгээс танилцана уу.
5		Зэрлэг ан амьтанд зориулан Нарны өргүүртэй худаг, гаргаж орон нутгийн байгууллагад хүлээлгэн өгөх, автомат камер суурилуулан мониторинг хийх	Дүйцүүлэн хамгаалах газар нутагт	Тогтмол хэрэгжүүлж байна	Зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022-2023 онд хийж гүйцэтгэсэн “Амьтны тархац нөөцийн судалгаа”-ны хүрээнд 2023 онд тусгай зориулалтын усан хангамжийн эх үүсвэр учраас хүний оролцоогүйгээр ажиллах бүрэн боломжтой, дуу чимээгүй, амьтныг үргээхгүйгээр ус гаргах, байхаар тоноглог Зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилго бүхий 1 ширхэг худаг, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх 3 худаг өрөмдөж, барилга байгууламжийг бүрэн хийж гүйцэтгэх ажлыг “Гранд холдинг” ХХК-тай гэрээ байгуулсан. Одоогийн байдлаар худгийн өрөмдлөгийн ажил 80 хувийн гүйцэтгэлтэйгээр хийгдэж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.6.5 хэсгээс танилцана уу.
6		Орон нутгийн байгууллагатай хамтран “Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээ”-ний	Уурхайн орчимд	Тогтмол хэрэгжүүлж байна	Ан амьтныг сэргээн нутагшуулах, үржүүлэх туршилт судалгааны ажил эрхлэх эрх бүхий мэргэжлийн байгууллага болох Авралын эрэлд ХХК-аар гүйцэтгүүлсэн судалгааны дүнгээр 6

		хөтөлбөрийг хэрэгжүүлэн уурхай орчмын малчин иргэдтэй хамтран амьтаны ажиглалт судалгаа хийх			багийн 32 зүйлийн хөхтөн амьтдыг ажиглаж, амьд баригчаар барьж тэмдэглэв. Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн 5 зүйл Цоохор ирвэс, Шилүүс, Янгир ямаа, Хар сүүлт, Таван хуруут атигдаахай тус уурхай орчимд байна. Шувуудаас 6 баг, 8 овгийн 31 зүйлийн 274 (ойролцоогоор) бодгалийг ажиглаж бүртгэсэн. Ингэхэд Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн Ооч ёл, Жороо тоодог, Монгол хулан жороо, Загийн бор шувуу зэрэг 4 зүйл байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.6.5 хэсгээс танилцана уу.
7		Уурхайн амьтаны нарийвчилсан судалгаанд үндэслэн тарвага нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Уурхайн орчимд	Тогтмол хэрэгжүүлж байна	“Амьтны аймгийн төрөл зүйл, тархац нөөц”-ийн судалгаанд үндэслэн БОАЖЯ-ны 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 06/1509 дугаар “Хан Алтай ресурс” ХХК-ийн ашиглалт олборлолтын талбай дахь тарвагыг Баян уул суманд дүйцүүлэн хамгаалал нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд сэлгэн нутагшуулах зөвшөөрөл”-ийг авч “Хан Алтай ресурс ХХК-ийн Байгаль орчны зохицуулагч Б.Бат-Эрдэнэ, Авралын эрэлд ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Зулбаяр, Ч.Бүүвэй болон тус компанийн холбогдох мэргэжлийн биологич нар 2023 оны 05 дүгээр сарын 01-ны өдрөөс 05-ны өдөр хүртэлх хугацаанд 1 дүгээр шатанд 25 толгой тарвага шилжүүлж хүлээлгэж өгсөн. 2-р шатанд 35 толгой тарвага тээвэрлэх, сэлгэн нутагшуулах үйл ажиллагааг зохион байгуулж амжилттай хэрэгжүүлсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг 2.6.6 хэсгээс танилцана уу.

2.6. Амьтан аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй

2.6.1. Орон нутагт ан хийхийг хориглох, галт зэвсэг хэрэгсэл байлгахыг хориглох талаар сурталчилах

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйл Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн нийтлэг үүрэгтэй уялдуулан төслийн нөлөөллийн бүс болоод уурхайн бүхий л үйл ажиллагааны хүрээнд галт зэвсэг, амьтан баригч урхи, хавх ашиглахыг хориглодог бөгөөд галт зэвсэг ашиглах, ан хийхийг хориглох талаар мэдээллийг орон нутгийн иргэдэд сурталчилж ажилласан. Тайлант онд хууль бус ан агнуур 1 бүртгэгдсэн.



Зураг 50. Галт зэвсэг хэрэгсэл, ан хийхийг хориглох мэдээлэл

Орон нутгийн иргэн галт зэвсэг ашиглан ан хийж байсан үйлдлийг газар дээр нь илрүүлж таслан зогсоох арга хэмжээ авч ажилласан.



Зураг 51. Ан хийж байсан үйлдлийг таслан зогсоосон

2.6.2. Тухайн нутагт нутагладаг зэрлэг амьтад болон мал үйлдвэрийн талбайд орох ухаш, шуудуунд унаж бэртэх, хорогдохоос урьдчилан сэргийлэх, нуруулдан уусгалтын талбайд шувуу үргээгч байрлуулах.

Нуруулдан уусгах байгууламжийн ашиглалтын явцад өртөж болзошгүй ан амьтны сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нуруулдсан хүдрийн хөмсөг дагуу 10-20 метрийн зайтайгаар толь болон 5 төрлийн дуу гаргагч шувуу үргээгч байрлуулсан байдаг. Тайлант онд 20 ширхэг Bird X Peller PRO шувуу үргээгчийг нуруулдан уусгах байгууламжийн далан, хөмсөгт нэмэгдүүлж байрлуулж өгсөн.

Төслийн талбайд 30 орчим зүйлийн шувуу судлан бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс 16 нь суурин нутагшдаг, 14 зүйлийн шувуу дамжин өнгөрдөг гүүдлийн байдалтай суурьшдаг. Үйлдвэрийн орчимд шувуудын үхэл хогрогдол бүртгэгдээгүй.



Зураг 52. Нуруулдан уусгах байгууламжид байрлуулсан шувуу үргээгч



Зураг 53. Bird X Peller PRO шувуу үргээгч

Тус нутаг нь газарзүйн байршлын хувьд судалгаагаар шувууны нүүдэл багатайд тооцогдох тул тооцоолол гарган 10кВ-ын ЦДАШ шугамд 8 ширхэг эргэлтийн болон төгсгөлийн анкер тулгуурууд дээр тус бүрт нь 2 ширхийг суурилуулсан байгаа юм. 35кВ-ын 10.8км ЦДАШ нь нийт 3 ширхэг анкер тулгууртай бөгөөд тус бүрт нь 3 ширхийг суурилуулсан байгаа болно.



Зураг 54. Цахилгаан дамжуулах агаарын шугам – Шувуу үргээгч

2.6.3. Нуруулдан уусгах байгууламж, баяжуулах үйлдвэрийн хэсэгт ан амьтан орохоос сэргийлж хашаажуулах

Ан амьтны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд Ан амьтан үхэж хорогдохоос сэргийлэх зорилгоор хүдэр баяжуулах үйлдвэр, Нуруулдан уусгах байгуумжид махчин болон хөхтөн, жижиг мэрэгч амьтад орохоос сэргийлэн 6000 гаруй метр сайн чанарын төмөр торон хашааг хийсэн.



Зураг 3 Мал амьтан орохоос сэргийлсэн хашаа хамгаалалт

Төслийн үйлдвэрийн бусад барилга байгууламжуудыг ашиглалтанд орсны дараагаар зэрлэг амьтан орох, эндэхээс сэргийлж хашаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Одоогийн байдлаар дараах байгууламжуудыг бүрэн хашаажуулсан. Үүнд:

- Уурхайн ажилчдын тосгон -
- Уурхайн шатахуун түгээх станц – 350 метр
- Бараа материалын агуулах – 150 метр
- Тэсрэх бодисын агуулах - 450 метр
- Энгийн хатуу хог хаягдлын цэг – 140 метр
- Баяжуулах үйлдвэр – 1000 метр
- Үндсэн хамгаалалтын хашаа – 6760 метр зэргийг хашаажуулаад байна.



2.6.4. Орон нутгийн байгууллагуудтай хамтран зэрлэг ан амьтанд өвөл, хаврын үед биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Амьтны амьдрах орчин, идэш тэжээлийн нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор төслийн ургамал, амьтны судалгаанд үндэслэн Янгир ямаа болон Хар сүүлт зээр нутагладаг 4 цэгт 50 пресс өвс тавьж өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан.



Зураг 55. Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн

2.6.5. Зэрлэг ан амьтанд зориулан Нарны өргүүртэй худаг, гаргаж орон нутгийн байгууллагад хүлээлгэн өгөх, автомат камер суурилуулан мониторинг хийх

Зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022-2023 онд хийж гүйцэтгэсэн “Амьтны тархац нөөцийн судалгаа”-ны хүрээнд 2023 онд тусгай зориулалтын усан хангамжийн эх үүсвэр учраас хүний оролцоогүйгээр ажиллах бүрэн боломжтой, дуу чимээгүй, амьтныг үргээхгүйгээр ус гаргах, байхаар тоноглог Зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилго бүхий 1 ширхэг худаг, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх 3 худаг өрөмдөж, барилга байгууламжийг бүрэн хийж гүйцэтгэх ажлыг “Гранд холдинг” ХХК-тай гэрээ байгуулсан. Одоогийн байдлаар худгийн өрөмдлөгийн ажил 80 хувийн гүйцэтгэлтэйгээр хийгдэж байна.



Зураг 56. Худгийн ажлын явц

2.6.6. Орон нутгийн байгууллагатай хамтран “Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээ”-ний хөтөлбөрийг хэрэгжүүлэн уурхай орчмын малчин иргэдтэй хамтран амьтаны ажиглалт судалгаа хийх

Ан амьтны тоо толгойн судалгаа хийх

Төслийн талбай болон ойр орчмын амьтны төрөл зүйлийн бүрдэл, нөөц тархац байршлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох, тэдгээрийн амьдрах орчинд үнэлгээ өгөх, төслийн талбайн уул ашиглалтын бүсэд амьтны аймгийн судалгаа болон тарваганы тоо толгой, тархац, нөөцийн судалгаа хийх, нүүлгэн шилжүүлэх тохиромжтой газрыг сонгох, нүүлгэн шилжүүлэх ажлын бэлтгэл хангах зорилгоор Хан Алтай төслийн байгаль орчны баг “Авралын Эрэлд” ХХК – тай хамтран судалгааг хийж гүйцэтгүүлсэн.



Зураг 57. Төслийн талбайн ан амьтны судалгааны хээрийн судалгааны ажил

2.6.7. Уурхайн амьтаны нарийвчилсан судалгаанд үндэслэн тарвага нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

“Амьтны аймгийн төрөл зүйл, тархац нөөц”-ийн судалгаанд үндэслэн БОАЖЯ-ны 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 06/1509 дугаар “Хан Алтай ресурс” ХХК-ийн ашиглалт олборлолтын талбай дахь тарвагыг Баян уул суманд дүйцүүлэн хамгаалал нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд сэлгэн нутагшуулах зөвшөөрөл”-ийг авч “Хан Алтай ресурс ХХК-ийн Байгаль орчны зохицуулагч Б.Бат-Эрдэнэ, Авралын эрэлд ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Зулбаяр, Ч.Бүүвэй болон тус компанийн холбогдох мэргэжлийн биологич нар 2023 оны 05 дүгээр сарын 01-ны өдрөөс 05-ны өдөр хүртэлх хугацаанд 1 дүгээр шатанд 25 толгой тарвага шилжүүлж хүлээлгэж өгсөн. 2-р үе шатанд 35 тарвага барьснаас 34-г ловонгийн нуруунд нүүлгэн шилжүүлсэн 1 тарвагыг ГАА- Зоонозын өвчин судлалын төв хүлээлгэн өгч акт үйлдсэн.





Зураг 58. Ловонгийн нуруунд тарвага нутагишуулсан ажлын явц

БҮЛЭГ ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Техникийн нөхөн сэргээлт	Уул олборлолтын бүсэд ашиглагдахгүй болсон зам талбайд техникийн нөхөн сэргээлт хийх.	га	3.2	Тогтмол хэрэгжүүлж байна	Хан Алтай төслийн хэмжээнд тухайн онд техникийн нөхөн сэргээлтийг дараах 3 хэсэгт хийж гүйцэтгэлээ. 1. Ус хангамжийн системийн барилга буцаан дүүргэлт, нөхөн сэргээлт 9,000м ² 2. Бохир усны шуудуу татах ажлын буцаан дүүргэлт, нөхөн сэргээлт – 5,100м ² Тайланд хугацаанд хаагдсан зам талбай гараагүй болно. Дэлгэрэнгүй мэдээллийг 3.1.1 хэсгээс танилцана уу.
2	Биологийн нөхөн сэргээлт	“Нөхөн сэргээлт” 2020 арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд хуурай үрлэгч ашиглан олон наст үр цацах	га	2.0	Төлөвлөж байгаа	Нөхөн сэргээлт 2020 арга хэмжээний хүрээнд Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 1/399 дугаар албан хүсэлтийн дагуу хууль бус гар аргаар алт олборлогчдын улмаас эвдрэлд орж орхигдсон “Шаврын голын Улаан хадны бэлчир”, Өлийн голын эх” нэртэй 5,59 га талбайд нөхөн сэргээлт хийх ажлыг “Баян боролдой” ХХК-тай гэрээ байгуулан 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн гүйцэтгүүлж байна. Тус ажлын гүйцэтгэлийн явцад эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссаны дараа олон наст үр цацаж усалгаа хийхээр төлөвлөж байна.

						Дэлгэрэнгүй мэдээллийг 3.1.2 хэсгээс танилцана уу.
3	Үржил шимт хөрсийг хуулж, 5 м-ээс өндөргүй овоолго үүсгэн хадгалах	га	2,0	Тогтмол хэрэгжүүлж байна		<p>Үржил шимт хөрсийг хуулах, хадгалах, нөхөн сэргээх ажлууд Монгол улсын MNS 5916:2008 стандартын шаардлага болон шимт хөрсний дотоодын менежмент систем, газар хөндөх зөвшөөрөлд тулгуурлан хэрэгжиж байна. Шимт хөрсний овоолгын өндөр 5 метрээс илүүгүй байх шаардлагыг баримталж байна. 2023 онд 8 газар 57,600м² 5.7га талбайд хөндөх зөвшөөрлийг олгож 3,202м³ шимт хөрс хуулсан.</p> <p>Шимт хөрсний овоолгод 251,264м³ шимт хөрс хадгалагдаж байна.</p> <p>Дэлгэрэнгүй мэдээллийг 3.1.3 хэсгээс танилцана уу.</p>
4	Үржил шимт хөрсийг сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс, уулын нугат хээрийн болон уулын нугын хөрсөөр 2 ангилан хэлбэржүүлэх	га	1,8	Тогтмол хэрэгжүүлж байна		<p>Төслийн талбайд шимт хөрсийг хүрээлэн буй орчин, хөрсний шинж чанар, төрөл зүйлээс хамааран ангилан Мецо бутлуурын баруун хойд хэсэгт байгуулсан. Үржил шимт хөрсийг сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс, уулын нугат хээрийн болон уулын нугын хөрсөөр 2 ангилан хэлбэршүүлэх ажлыг шимт хөрсний менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс – 16584м³ ✓ Уулын нугат хээрийн болон уулын нугын хөрс - 16584м³ <p>Дэлгэрэнгүй мэдээллийг 3.1.4 хэсгээс танилцана уу</p>

3.1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн дэлгэрэнгүй

3.1.1. Уул олборлолтын бүсэд ашиглагдахгүй болсон зам талбайд техникийн нөхөн сэргээлт хийх.

Хан Алтай төслийн хэмжээнд тухайн онд техникийн нөхөн сэргээлтийг дараах 3 хэсэгт хийж гүйцэтгэлээ.

1. Ус хангамжийн системийн барилга буцаан дүүргэлт, нөхөн сэргээлт 9,000м²
2. Бохир усны шуудуу татах ажлын буцаан дүүргэлт, нөхөн сэргээлт – 5,100м²

2023 оны БОМТ-ний Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Уул олборлолтын бүсэд ашиглагдахгүй болсон зам талбайд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн боловч төслийн үйл ажиллагааны удаашралаас хамааран хаагдсан зам талбай гараагүй болно.



Зураг 59. Төслийн усан хангамжын нэгдсэн системийн техникийн нөхөн сэргээлт

3.1.2. “Нөхөн сэргээлт” 2020 арга хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэсэн техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд хуурай үрлэгч ашиглан олон наст үр цацах

Нөхөн сэргээлт 2020 арга хэмжээний хүрээнд Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн 1/399 дугаар албан хүсэлтийн дагуу хууль бус гар аргаар алт олборлогчдын улмаас эвдрэлд орж орхигдсон “Шаврын голын Улаан хадны бэлчир”, Өлийн голын эх” нэртэй 5,59 га талбайд нөхөн сэргээлт хийх ажлыг “Баян боролдой” ХХК-тай гэрээ байгуулан 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн гүйцэтгүүлж байна. Тус ажлын гүйцэтгэлийн явцад эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссаны дараа олон наст үр цацаж усалгаа хийхээр төлөвлөж байна.



Зураг 60. Техникийн нөхөн сэргээлт хийж байгаа нь

3.1.3. Үржил шимт хөрсийг хуулж, 5 м-ээс өндөргүй овоолго үүсгэн хадгалах

Үржил шимт хөрсийг хуулах, хадгалах, нөхөн сэргээх ажлууд Монгол улсын MNS 5916:2008 стандартын шаардлага болон шимт хөрсний дотоодын менежмент систем, газар хөндөх зөвшөөрөлд тулгуурлан хэрэгжиж байна. Шимт хөрсний овоолгын өндөр 5 метрээс илүүгүй байх шаардлагыг баримталж байна. 2023 онд 8 газар 57,600м² 5.7га талбайд хөндөх зөвшөөрлийг олгож 3,202м³ шимт хөрс хуулсан.

Шимт хөрсний овоолгод **251,264м³** шимт хөрс хадгалагдаж байна.






Зураг 61. Шимт хөрсний овоолго

3.1.4. Үржил шимт хөрсийг сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс, уулын нугат хээрийн болон уулын нугын хөрсөөр 2 ангилан хэлбэржүүлэх

Төслийн талбайд шимт хөрсийг хүрээлэн буй орчин, хөрсний шинж чанар, төрөл зүйлээс хамааран ангилж Шимт хөрсний менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан компанийн гүйцэтгэх захирал болон холбогдох удирдлагуудаар батлуулан Мецо бутлуурын баруун хойд хэсэгт байгуулсан. Үржил шимт хөрсийг сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс, уулын нугат хээрийн болон уулын нугын хөрсөөр 2 ангилан хэлбэршүүлэх ажлыг шимт хөрсний менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Үүнд:

- ✓ Сайр чулуурхаг цайвар хүрэн хөрс – 16584м³
- ✓ Уулын нугат хээрийн болон уулын нугын хөрс -4758 м³





ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ


Дүйцүүлэн хамгаалах ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар хэрэгжүүлэн, тайлагнаж байна.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	ГАА-ийн багийн нутагт хууль бусаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдрэлд орсон газрын нөхөн сэргээлт хийх	“Нөхөн сэргээлт” 2020 арга хэмжээний хүрээнд хууль бусаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх	Есөнбулаг сум	5 га	Төлөвлөж байгаа	"Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээх" арга хэмжээний хүрээнд Есөнбулаг сумаас Өлийн гол, Шаврын голын Улаан хадны бэлчир нэртэй газарт хууль бусаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн 5.59 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх саналыг ирүүлсэн. Тус ажлын хүрээнд нөхөн сэргээлтийн ажлыг тусгай зөвшөөрөл “Баянборолдой” ХХК-р 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн гүйцэтгүүлж байна. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах хэсгээс танилцана уу.
2	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг сонгох	Говь-Алтай аймаг	1	Бүрэн хэрэгжсэн	Төсөл хэрэгжүүлэгч, мэргэжлийн байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын төлөөллүүд хамтран хийсэн хэлэлцүүлгийн үр дүнгээс “Хан алтай” төслийн дүйцүүлэн хамгааллын талбайг Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэр болох “ Арын хүрээний туурь ” болон “ Зайвар ” нэртэй талбайг сонгосон. Хамгаалах шаардлагатай үнэт зүйлс нь: 1. Шинэсэн ой 2. Шавартын булаг


						3. Голын экосистем /Шавартын гол/ зэрэг болно. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах хэсгээс танилцана уу.
3		Сонгогдсон тусгай хамгаалалттай газар нутагт хүрээлэн буй орчин, байгаль цаг уурын суурь судалгаа хийх	Говь-Алтай аймаг	1	Бүрэн хэрэгжсэн	“Грийн Ассесмент” ХХК Мэргэжлийн байгууллага нь дээрх 2 талбайд хээрийн судалгааг гүйцэтгэж Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, биологийн олон янз байдлын суурь судалгаа, өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээг хийсэн. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах хэсгээс танилцана уу.
4		Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачлагын хүрээнд ГАА-ийн 108сая мод тарих аянд нэгдэн ГАА-ийн Наран багийн Элгэн булгийг түшиглэн мод үржүүлгийн талбай талбай байгуулах	ш	1	Бүрэн хэрэгжсэн	“Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачилгын хүрээнд ГАА-ийн 108сая мод тарих аянд нэгдэн 1.2 га талбайд Мод үржүүлгийн талбай талбай байгуулан 6x50 метрийн хэмжээтэй 2 ширхэг зуны нарлаг хүлэмжид 4 төрлийн мод, 1 төрлийн цэцэг үрслүүлэн амжилттай уруулж байна. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2.4.3 хэсгээс танилцана уу.

4.1. “Нөхөн сэргээлт” 2020 арга хэмжээний хүрээнд хууль бусаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх

"Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээх" арга хэмжээний хүрээнд Есөнбулаг сумаас Өлийн гол, Шаврын голын Улаан хадны бэлчир нэртэй газарт хууль бусаар ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн 5.59 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх саналыг ирүүлсэн. Тус ажлын хүрээнд нөхөн сэргээлтийн ажлыг тусгай зөвшөөрөл “Баянборлолдой” ХХК-р 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн гүйцэтгүүлж байна.



Зураг 62. Есөнбулаг сумын засаг даргын албан хүсэлт



Зураг 63. Өгийн гол нөхөн сэргээлт хийх талбай /1.07га/



Зураг 64. Шаврын гол Улаан хадны бэлчир /4.52га/

4.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг сонгох

Дүйцүүлэн хамгаалах газрын байршлыг талуудын оролцоотойгоор тогтоосон байдал

Хан Алтай төслийн дүйцүүлэн хамгаалах газрыг сонгохдоо уурхай орчмын экосистемүүдтэй тэнцүү эсвэл илүү том хэмжээгээр агуулсан талбайг тухайн экологийн бүс нутгийн хэмжээн дэх улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг /УТХГН/ дундаас сонгосон. Үүнд

1. Бүс нутгийн хэмжээнд дүйцүүлэн хамгаалах боломжтой газар нутаг
2. Аймгийн хэмжээнд дүйцүүлэн хамгаалах боломжтой газар нутаг
3. Сумын хэмжээнд дүйцүүлэн хамгаалах боломжтой газар нутаг
4. Орон нутгийн тусгай хэрэгцээний газар нутагт дүйцүүлэн хамгаалах боломжтой газар нутаг зэрэг болно.

Дүйцүүлэн хамгааллын зорилго нь амьдрах орчныг дүйцүүлэн хамгаалахад чиглэгдэж байгаа тул нөлөөлөлд өртсөнтэй экологийн хувьд аль болох "ижил" төрлийн бүтэц, хэв шинж, үнэ цэнэ, үйл явц бүхий амьдрах орчныг сонгон авч дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Дүйцүүлэн хамгааллын байршлыг тогтоохдоо тухайн нөлөөлөлд өртсөн “Сав газар” эсвэл “Экологийн бүс”-ийн хүрээнд байх зарчмыг баримталсан. Ялангуяа ихэнх тохиолдолд тухайн нөлөөлөлд өртсөн газрын нутгийн иргэд, орон нутгийн удирдлага дүйцүүлэн хамгааллыг аль болох өөрийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхийг эрмэлздэг тул дүйцүүлэн хамгаалах газрыг сонгохдоо төслийн нөлөөлөл өртсөн газартай ойр байх, тухайн Засаг захиргааны хилийг харгалзан үзсэн.


Дүйцүүлэн хамгаалах газрыг сонгохдоо олон нийтийн оролцоог хангах үүднээс дээр дурдсан дүйцүүлэн хамгааллын зарчмыг баримтлан төсөл хэрэгжүүлэгч “Хан Алтай Ресурс” ХХК, мэргэжлийн байгууллага болох “Грийн Ассесмент” ХХК хамтран Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, бусад төрийн захиргааны

байгууллагын төлөөллийг оролцуулан 2023 оны 4-р сарын 28-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, олон нийтийн оролцоотойгоор дүйцүүлэн хамгаалах боломжтой газар нутгийг сонгосон.




Зураг 65. Оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт

Төсөл хэрэгжүүлэгч болон дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө боловсруулсан мэргэжлийн байгууллагын хувьд улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг дундаас бүс нутаг, аймаг, сум, орон нутгийн тусгай хэрэгцээний газруудаас дүйцүүлэн хамгаалах боломжтой газар нутгуудыг танилцуулсан бөгөөд Хан Алтай төслийн талбайн нөлөөлөлд өртөх талбайтай экологийн хувьд ижил төстэй байдал, экосистемийн хэв шинж, үнэ цэнэ, амьдрах орчны талаар тайлбар хийсэн. Төсөл хэрэгжүүлэгч, мэргэжлийн байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагын төлөөллүүд хамтран хийсэн хэлэлцүүлгийн үр дүнгээс “Хан алтай” төслийн дүйцүүлэн хамгааллын талбайг Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэр болох “**Арын хүрээний туурь**” болон “**Зайвар**” нэртэй талбайг сонгож дүйцүүлэн хамгааллын суурь судалгаа хийж, энэхүү 2 талбайгаас дүйцүүлэн хамгаалал арга хэмжээ хэрэгжүүлэх газрыг сонгохоор харилцан тохиролцсон.



Зураг 66. Хээрийн судалгаа хийсэн байршлын зураг



Зураг 67. Хан Алтай төслийн нөлөөлөлд өртөх талбай

4.3. Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачилгын хүрээнд ГАА-ийн 108сая мод тарих аянд нэгдэн ГАА-ийн Наран багийн Элгэн булгийг түшиглэн мод үржүүлгийн талбай талбай байгуулах

“Монгол улсын Ерөнхийлөгчийн “Тэр бум мод тарих” санаачилгын хүрээнд ГАА-ийн 108сая мод тарих аянд нэгдэн 1.2 га талбайд Мод үржүүлгийн талбай талбай байгуулан 6х50 метрийн хэмжээтэй 2 ширхэг зуны нарлаг хүлэмжинд 4 төрлийн мод, 1 төрлийн цэцэг үрслүүлэн амжилттай уруулж байна.



Зураг 68. Мод үржүүлгийн талбайн байршил

Үрээр модны суулгац бэлтгэх 6х50 хэмжээтэй Солонгос улсад үйлдвэрлэгдсэн дуслын усалгааны системээр бүрэн тоноглогдсон 2 ширхэг хүлэмжийг худалдан авах, газар дээр нь угсралтыг хийж гүйцэтгэх гэрээг “Алтын сапа ХХК-тай байгуулсан. Мөн мод үржүүлгийн газрын усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Засагт ханы өнгө” ХХК-тай гэрээ байгуулан 80 метрийн гүнтэй 1.2 л/с ундаргатай худгийг өрөмдөж бүрэн тоногдсон.



Зураг 69. Мод үржүүлгийн талбайн ерөнхий төлөвлөгөө

“ХАН АЛТАЙ РЕСУРС” МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР

Мод үржүүлгийн газрын төлөвлөлт зохион байгуулалтын дагуу 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс үйл ажиллагаагаа эхлэн хөрс боловсруулалтын ажлыг хийж 2023 оны 07 сарын 27-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл тарилтын ажлыг явуулсан. Үрийн соёлолт 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхэлсэн бөгөөд одоогоор 90%-ийн соёлолт, ургалттай байна.

Соёлолт явагдаагүй байгаа үрийн хатгаа авах, соёолж эхэлж байгаа үрийн өсөлт удаашрах явц болон соёлолт эрчимтэй явагдаж байгаа үрийн соёлолтод шаталт явагдах эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хүлэмжийн чийгийн болон температурын баланс, хүлэмжийн гадна агаарын температур, чийгийн баланс зэргийг харгалзан үзэж агаар сэлгэлтийн ажил тогтмол хийгдэж байна.

Өргөө кемп, Мод үржүүлгийн газрын хүлэмж болон хүлэмжийн гаднах талбайн хог ургамлыг тогтмол түүж ургамал ургах ая тухтай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Хүлэмжид:

- ✓ Хайлас модны үр -5кг
- ✓ Шархуйс модны үр -5кг
- ✓ Агч модны үр -5кг
- ✓ Бүйлс модны үр -5кг
- ✓ Мерабилес цэцгийн үр -2,5кг тус бүр тариалсан.

1. Хүлэмжийн хөрс боловсруулалтын ажил



Зураг 70. Хүлэмжний хөрс боловсруулалтын ажил

2. Хүлэмжийн тариалалтын ажил



Зураг 71. Хүлэмжний тарилтын ажил



Зураг 72. Тариалалт хийсний дараах байдал

3. Модны үрсэлгээг хаягжуулж ургалт



Зураг 73. Модны үрсэлгээний ургалт

БҮЛЭГ ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Бид “Нийгмийн хариуцлагын гэрээ - 2023”-ын дагуу Орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөрөө боловсруулан, түүнийхээ үүрэг амлалтыг хэрэгжүүлэн ажиллалаа.

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Нүүлгэн шилжүүлэх айл өрх	Төслийн талбайгаас нүүлгэн шилжүүлэх	Төсөлд хамрагдсан өрхийн тоогоор	3	Хэрэгжиж байна.	Тус үйл ажиллагааны хүрээнд 2022 оны 4-р сард Н-71-БУ-22/9 тоот НОГэрээ байгуулсан нөлөөллийн бүсийн малчин Д. Мягмарсүрэнгийн “Дашим” хэмээх бууцыг чөлөөлж, уурхайн бүсээс 35 кмт орших “Бага булаг” хэмээх газарт нүүлгэн шилжүүлэлтийн ажил хийгдэж байна. Өвөлжөөг паалкаар барихаар тохиролцон талбай засах, буурь цуглах өвөлжөөний суурийн ажил хийгдсэн. Өвөлжөө барих ажил материалын худалдан авалт хийгдэж байна.
2	Нөхөн олговор олгох айл өрх	Малчин өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих	Харилцан тохиролцоно	6	Хэрэгжиж байна.	Үйл ажиллагааны хүрээнд “Түлэнхий” хэмээх бууцыг чөлөөлөхөөр 2023 оны 07 сард ОНТ-РО-4011 тоот гэрээг нөлөөллийн бүсийн малчин Ч. Эсмаатай байгуулж , гэрээний дагуу нөхөн олговрыг төлж барагдуулсан.

5.1. Нүүлгэн шилжүүлэлтийн биелэлт:

Хан Алтай ресурс ХХК-ийн хэрэгжүүлж буй “Хан Алтай” төслийн MV-021537 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нийт 13 өрхийн 16 албан ёсны гэрчилгээтэй айл өрхийн өвөлжөө хаваржаа давхцалтай байдаг.

Тус айл өрхүүдтэй 2022 онд 6 айл өрхтэй харилцан тохиролцож “Нөхөн олговрын гэрээ”-г байгуулсан. Мөн 2022 онд нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөсөн 7 айл өрхөөс 5 айл өрх “Хан Алтай ресурс” ХХК-аар нүүлгэн шилжүүлүүлэхээс татгалзаж гарах зардлыг мөнгөн хэлбэрээр авах хүсэлт өгч шийдвэрлүүлсэн. Харин 2 айл өрх компанийн зардлаар нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх санал гаргаж 2023 онд тус 1 айл өрхийг нүүлгэн шилжүүлэх ажил хийгдсэн.



График 4 Нөхөн олговрын гэрээний статус



График 5 Нүүлгэн шилжүүлэлтийн статус

Тус үйл ажиллагааны хүрээнд 2022 оны 4-р сард Н-71-БУ-22/9 тоот НОГэрээ байгуулсан нөлөөллийн бүсийн малчин Д. Мягмарсүрэнгийн “Дашим” хэмээх бууцыг чөлөөлж, уурхайн бүсээс 35 кмТ орших “Бага булаг” хэмээх газарт нүүлгэн шилжүүлэлтийн ажил хийгдэж байна. Өвөлжөөг

паалкаар барихаар тохиролцон талбай засах, буурь цутгах өвөлжөөний суурийн ажил хийгдсэн. Өвөлжөө барих ажил материалын худалдан авалт хийгдэж байна.



Зураг 74. нүүлгэн шилжүүлэлтийн ажил

5.2. Нөхөн олговрын биелэлт:

3	Хөрсөн бүрхэвч	Хөрсний чанар-хими, физикийн ерөнхий үзүүлэлтүүд (Cr, Cd, Pb, Ni, Zn) агууламжийг тодорхойлох	Хайгуулын кемпийн орчимд-оффисын ард талбайгаас SSP-1 Хайгуулын кемпээс урагшаа 1,3 км-ийн зайнаас SSP-2 Хайгуулын кемпээс зүүн урагшаа – 500 м SSP-3 Баяжуулах үйлдвэр барихаар төлөвлөж буй талбайн орчим SS-4 Хөрсний овоолго барихаар төлөвлөж буй талбайн орчим SS-5	Сар тутам	Бүрэн хэрэгжсэн	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн байгууллага болох “Смарт Лаб” ХХК-тай гэрээ байгуулан сард 1 удаагийн давтамжтай төслийн талбай орчмын хөрснөөс дээж авч хөрсний хяналт шинжилгээг хийж байна. Үүнд сар тутам <ul style="list-style-type: none"> ✓ Хөрсний хяналт шинжилгээ - 26 дээж ✓ Хөрсний ялзмаг, карбонат - 4 дээж ✓ Хөрсний нийт болон чөлөөт цианид - -3 дээж ✓ Хаягдал чулуулгийн хяналт шинжилгээ – 20 дээж Шинжилгээний үр дүнг MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын стандартаа харьцуулж шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. Үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг 9.3. хэсгээс танилцана уу.
4	Хөрсний чанар- хүнд металлууд	Хөрсний чанар- хүнд металлууд	Нуруулдан уусгалтын талбай Ил уурхай Бутлуурын талбай Ажилчдын хотхон, бохир цэвэрлэх байгууламжийн орчим Хог булшлах цэгийн орчим	Сар тутам	Бүрэн хэрэгжсэн	
5	Усны чанар, нөөцийн мониторинг	Усны түвшин	Хайгуулын кемпийн гал тогоо WS-1, ХЦ-4, ХЦ-5, ХЦ-7, ХЦ-6, ХЦ-9, Цолмонгын гар худаг, Бага Цахирын булаг, Дэрст худаг, Цахир булаг, Элгэн булаг, МЦ-1, ЭЦ-23, ЭЦ-12, Булаг-1, ХЦ-11, MW-3, MW-4, MW-5, Гол-1	Сар тутам	Бүрэн хэрэгжсэн	Усны түвшний мониторинг хэмжилтийг In-Situ Water Level Meter 100м багажаар хяналт мониторингийн 11 цэгт 7 хоногт 1 удаагийн давтамжтай хийж хэмжилтийн дүнг нэгдсэн мэдээллийн санд бүртгэн авч ажилласан. Мөн Смартлаб ХХК сар бүр хяналтын цооногуудын түвшинг хэмжиж тайланд мэдээ ирүүлсэн байна. Үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг 9.4. хэсгээс танилцана уу.

6		Ca, Mg, Cl, SO4, NO2, К-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулгийг тодорхойлох	Хайгуулын кемпийн гал тогоо ХЦ-1, ХЦ-2, ХЦ-4, ХЦ-5, ХЦ-7, ХЦ-6, ХЦ-9, Цолмонгын гар худаг, Бага Цахирын булаг, Дэрст худаг, Цахир булаг, Элгэн булаг, МЦ-1, ЭЦ-23, ЭЦ-12, ХЦ-11, MW-3, MW-4, MW-5	Сар тутам		<p>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн байгууллага болох “Смарт Лаб” ХХК-тай гэрээ байгуулан сард 1 удаагийн давтамжтай төслийн талбай орчмын уст цэгүүдээс дээж авч усны хяналт шинжилгээг хийж байна. Үүнд сар тутам</p> <ul style="list-style-type: none"> ✓ Гадаргын болон гүний усны хяналт шинжилгээ- 23 дээж ✓ Усны микробиологийн шинжилгээ - 5 дээж ✓ Усны нийт болон чөлөөт цианид - 4 дээж <p>Үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг 9.5. хэсгээс танилцана уу.</p>
7		Ундны ус, чанарын үзүүлэлт	Хайгуулын кемпийн гал тогоо ХЦ-1, ХЦ-2, ХЦ-4, ХЦ-5, ХЦ-7, ХЦ-6, ХЦ-9, Цолмонгын гар худаг, Бага Цахирын булаг, Дэрст худаг, Цахир булаг, Элгэн булаг, МЦ-1, ЭЦ-23, ЭЦ-12, ХЦ-11, MW-3, MW-4, MW-5	Сар тутам		
8		Унд, ахуйн усны нян тодорхойлох	Бөөрийн булаг, Бага Цахирын булаг, ХЦ-04, ундны усны машин, Гал тогооны крант, гал тогооны ус хадгалах сав, Унд ахуйн нөөцийн сав, Гал тогооны крант 2	Улирал тутам		
9		Хаягдал усны хяналт шинжилгээ	Ажилчдын хотхоны цэвэрлэх байгууламжид хаягдал усны шинжилгээ хийх	Улирал тутам		
10	Ургамлан бүрхэвч	Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо, дундаж өндөр, бүрхэц,%	Шимт хөрсний овоолго	Жилд 1 удаа	Бүрэн хэрэгжсэн	<p>Тус ажлын хүрээнд Байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “ЭКО ЭСТИМЕЙТ” ХХК-р Ургамлын аймгийн нарийвчилсан судалгааг хийлгэсэн. Энэхүү судалгааны MV-021537 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 6793 га талбайн хүрээнд 32 овог, 85 төрлийн 127 зүйл ургамал тархсаныг тодорхойлноос гадна зургаан томоохон бүлгэмдэл илрүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Олон наст өвслөг ургамал 86 зүйл 68%

						<ul style="list-style-type: none"> ✓ Нэг наст өвслөг ургамлууд 25 (20%), ✓ Сөөг, сөөгөнцөр ургамлууд 16 (12%) <p>Үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг 9.6. хэсгээс танилцана уу.</p>
11	Орчны физик үзүүлэлтүүд	Дуу шуугианы хэмжилт хийх	Ил уурхайн орчимд ХБҮ-ийн орчим	Сар тутам, 24 цагийн турш	Бүрэн хэрэгжсэн	<p>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн байгууллага болох “Смарт Лаб” ХХК-тай гэрээ байгуулан сард 1 удаагийн давтамжтай бутлуурын талбай, хүдэр баяжуулах үйлдвэр цэг дээр дуу шуугианы хэмжилтийг хийж байна. Дуу шуугианы хэмжитлийг MNS 4585:2007 стандартад заасан зөвшөөрөгдөх хэм хэмжээтэй харьцуулж тайлан боловсруулж ажилласан.</p> <p>Үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг 9.7. хэсгээс танилцана уу.</p>

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ


“Хан Алтай” төслийн үйл ажиллагааны хүрээнд 2023 онд “Байгаль орчны хяналт шинжилгээ”-ний хөтөлбөрийг Ус, Агаар, Хөрс, Хаягдал чулуулгийн үндсэн шинж чанарыг тодорхойлох төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдэд хяналт тавьж цаашдын арга хэмжээг төлөвлөх зорилгоор байгаль орны мэргэжлийн байгууллага болох “Смарт Лаб” ХХК-тай гэрээ байгуулан сар бүр хяналт шинжилгээний дээжлэлт, хэмжилт судалгааг хийж гүйцэтгэн ажилласан. Хэмжилт судалгааны үр дүнг 2021 оны суурь түвшинтэй харьцуулах замаар сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон сар,улирал, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласан.



“ХАН АЛТАЙ” ТӨСЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

УС	ХӨРС	АГААР	ХАЯГДАЛ ЧУЛУУЛАГ	НЯН
				
11 ЦЭГТ	15 ЦЭГТ	6 ЦЭГТ	10 ЦЭГТ	4 ЦЭГТ

НИЙТ 46 ЦЭГТ 138 ДЭЭЖ



Мөн БОАЖЯ-ын сайдын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/160 дугаар тушаалаар томилогдсон “Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулах, төслийн үйл ажиллагаанаас нутгийн иргэд болон хүрээлэн буй орчинд нөлөөлж буй нөлөөллийг тодорхойлох” ажлын хэсэг 2023 оны 09 дүгээр сарын 06-07-ны өдрийн хооронд ажиллаж “Хан Алтай” төслийн байгаль орчны хяналт шинжилгээний цэгүүдэд болон сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй цэгүүдэд 114 дээжлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн холбогдох зөвлөмжүүдийг өгч ажилласан.

Зураг 85 Байгаль орчны хяналт шинжилгээ



Хяналт шалгалтын хүрээнд хийгдсэн Байгаль орчны хяналт шинжилгээ /Дээжний тоо/




График 7 БОАЖЯ ажлын хэсгийн “Хан Алтай” төслийн талбайд хийгдсэн дээжлэлтүүд

Агаарын чанарын хяналт шинжилгээ:

Төслийн талбайн агаарын бохирдлыг үнэлэх зорилгоор агаарын үзүүлэлтүүдийг 10 цэгт тодорхойлов. Үүнд:

Агаар дах PM2.5, PM10 тоосонцрын агууламжийг Smart 8000 зөөврийн багаж, SO₂, O₂, NH₃, CO-ийн агууламжийг Draeger 5000 х-ам зөөврийн багаж ашиглан 10 цэгт хэмжилт сар тутам тогтмол хийж хэрэгжүүлдэг. Мөн 2022 онд 7 хоног тутам PCE-11 багажаар дотооддоо PM 2.5, 10 тоосонцрыг тогтмол хэмжиж ажиллаж байна. Агаарын чанарын судалгаагаар төслийн талбайн орчин нь MNS 4585:2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага, Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартыг харьцуулан ажилласан.

Хүснэгт 17 Агаарын чанарын хяналт шинжилгээний цэгийн жагсаалт

Д/д	Дээжийн дугаар	Координат		Өндөршил
1	KhaS-010 Air	96° 53' 5.834" E	46° 3' 16.088" N	1811
2	KhaS-027 Air	96° 94' 5.90" E	46° 10' 2.64" N	2436
3	ЭЦ-5	96° 55' 27.350" E	46° 2' 30.440" N	1826
4	ХЦ-2 Air	96° 54' 9.560" E	46° 4' 38.600" N	1996
5	KhaS-022 Air	96° 57' 38.900" E	46° 4' 10.724" N	2119
6	Хайрганы карьер	96° 55' 15.462" E	46° 3' 37.815" N	1867
7	Khas-023	96° 56' 19.110" E	46° 3' 15.165" N	1880
8	Шинэ кемп	96° 52' 6.391" E	46° 4' 12.642" N	1826
9	Бага цахир булаг	96° 53' 32.956" E	46° 5' 4.002" N	1975
10	Буур булаг	96° 54' 38.373" E	46° 5' 51.427" N	2128
11	Гар худаг	96° 52' 20.024" E	46° 4' 40.567" N	1908

Ялгарах бохирдуулагчид SO₂, CO, NO₂ үзүүлэлтүүдийн үр дүн

Агаарын чанарын мониторингийг “Смарт Лаб” компани сар бүр хяналтын 9 цэгт 1 удаа гүйцэтгэж, холбогдох үр дүнг стандарттай харьцуулан тайлагнасан. Мониторингийн хэмжилтийн багаж агаарын найрлагыг хэмжигч Драгер Х – 5600 бөгөөд тухайн багаж нь дараах 4 элементийг хэмждэг.




График 8 Агаар дахь хүчил төрөгчийн хэмжээ




График 9 Агаар дахь хүхрийн ислийн хэмжилт




График 10 Нүүрс төрөгчийн дутуу ислийн хэмжилт





График 11 Аммиагийн хэмжилт

Агаарын чанарын дүгнэлт:

Дээрх 4 төрлийн хийн хэмжилтийн мониторингийн үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна.

- Байгаль дах хүчилтөрөгчийн хэвийн хэмжээ стандарт хэмжээтэй харьцуулахад өөрчлөлтгүй, хяналтын 9 цэгт хэвийн байна.
- Хүхрийн дутуу ислийн хэмжээ өвлийн улиралд засварын цех, гагнуурын цехийн орчимд стандартаас давсан тохиолдлууд бүртгэгдсэн байна. Тухайн хэсэгт агаарын найрлагыг өөрчилж буй хүхрийн агууламж өндөр концентраци байгаа бөгөөд агааржуулалт сайн хийх, битүү орчинд ажиллахгүй байх, амьсгал хамгаалах хэрэгслийг тухайн бүсэд ашиглах боломжтой. Түүнчлэн, техникийг асаалттай засвар үйлчилгээг хийхгүй байх шаардлагыг техник засвар үйлчилгээний хэлтэст мэдээллэсэн.
- Нүүрстөрөгчийн дутуу исэл хяналтын 9 цэгт стандарт хэмжээндээ байгаа хэдий ч мөн өвлийн улиралд засвар, гагнуурын цехийн орчимд өндөр байна. Аюултай шингэн хог хаягдлыг ууршихаас урьдчилан сэргийлж, битүүмжийг сайжруулах, хөрсөнд бодис урвалж асгарсан бол цэвэрлэх, техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, тухайн хэсгүүдэд агааржуулалт сайн хийх зэрэг арга хэмжээг авч ажиллалаа.
- Аммиакийн хувьд хяналтын цэгүүд дээр илэрц бүртгэгдээгүй. Ирэх онд хүдэр боловсруулах үйлдвэр ашиглалтад орж, химийн бодис урвалжууд ашиглагдаад ирэхээр агаарын найрлагад өөрчлөлт орох боломжтой. Бидний хийсэн энэ үр дүнгүүд маань химийн бодис ашиглаагүй байх үеийн хэмжилт мониторингууд бөгөөд харьцуулсан судалгаа хийх суурь мэдээлэл болох юм.

Хан Алтай төслийн байгаль орчны багийн хувьд агаарын чанарын шинжилгээг 7 хоног тутамд хяналтын 9 цэгт хийж гүйцэтгэдэг бөгөөд 4 долоо хоногийн хэмжилтийн үр дүнгийн дунджаар сарын үр дүнг бүртгэн шинжлэв.



.График 12 Агаар дахь метаны агуулга




График 13 Агаар дах Хүхэрт устөрөгчийн хэмжилт




График 14 Агаар дахь Нүүрстөрөгчийн дутуу ислийн хэмжилт

Агаарын чанарын дүгнэлт:


Бид өөрсдийн хийж гүйцэтгэсэн агаарын чанарын 5 химийн нэгдлийн хэмжилтийн үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна.

- Агаар дах түгээмэл тархацтай химийн бохирдуулагчид болох метан, хүхэрт ус төрөгч, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг бодисуудын хувьд хүрээлэн буй орчны агаарт дэгдэж буй концентрацийн хувь стандарт хэмжээндээ байна. Гэхдээ нүүрстөрөгчийн дутуу исэл гагнуурын цех, засварын цех болон нуруулдан уусгах байгууламж дээр тодорхой төвшинд илэрч байна. Цаашид халаалтын зуухнууд ашиглалтад орох, хөдөлгөөнт техникийн тоо нэмэгдэхэд азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, нүүрсхүчлийн хий, хүхэрлэг хий нэмэгдэх боломжтой. Иймд хяналтыг тогтмол гүйцэтгэх, халаалтын зуухны яндангийн шүүгч, шингээгч тогтмол хэвийн ажиллаж байх шаардлагатай.
- Хүчилтөрөгчийн хэмжээ стандарт шаардлагаа хангаж байгаа бөгөөд цаашид тогтмол хэмжин бүртгэнэ.
- Хэдийгээр тайлант онд химийн бодис урвалж ашиглаагүй ч бид цианид устөрөгч буюу синилийн хүчлийн хэмжээг мөн хяналтын цэгүүд дээрээ гүйцэтгэлээ. Натрийн цианид ашиглаагүй тул илэрц байхгүй байгаа ч ашиглаад эхлэх үед агаарт синилийн хүчил үүсч болзошгүй. Хүдэр боловсруулах үйлдвэр, урвалжийн агуулах, лаборатори, нуруулдан уусгах байгууламж зэрэгт цаашид синилийн хүчлийн хэмжээг тогтмол шалгаж, мониторинг хийнэ.

Тоосны хэмжилт PM 2.5, PM 10 Тоосны чөлөөт уналт, тоосны тархалт

Байгаль орчны багаас 7 хоног тутамд хэмжилтийн 6 цэг дээр хяналт шинжилгээг тогтмол гүйцэтгэсэн бөгөөд тоосны хэмжилтийн үр дүн, харьцуулалт агаарын чанарын хэсэгт дурдагдсан.

График 15 Агаар дах тоосонцрын хэмжээ PM 2.5, PM 10 нарийвчлалаар



Зураг 86 Агаар дахь химийн үзүүлэлт тодорхойлолт

Нэгдсэн дүгнэлт:

“Хан Алтай” төслийн талбайд 6 цэгийг сонгон 7 хоног бүр агаар дахь PM 2.5, PM 10 тоосонцор, сар бүр агаар дахь Озон (O₃), Хүхэрлэг хий (SO₂), Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) -ын хэмжээг тодорхойлон ажилласан бөгөөд хэмжилтийн үр дүнг, Агаарын чанар: Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2007 стандартын өдрийн дундаж агууламжтай харьцуулалт хийхэд тус 6 цэгт 15 удаагийн хэмжилтээр бутлуур орчмын PM 2.5, PM 10 тоосонцрын хэмжилтийн үр дүн стандартаас давсан бөгөөд бусад химийн үзүүлэлтүүд стандартаас давсан үзүүлэлт гараагүй байна. Харин тус үзүүлэлтүүдийг өдрийн дунджаар авч үзэхэд стандартаас давсан үзүүлэлт гарахгүй байна. Тус үзүүлэлтийг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/327 тоот тушаалаар

батлагдсан “Агаарын чанарын индексээр үнэлэх, мэдээлэх ерөнхий журам”-ын дагуу үнэлгээ өгөхөд цэвэр буюу “Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй” байхаар үр дүн гарсан байна.

9.1. Хөрсний чанарын хяналт шинжилгээний тайлан:

Хөрсний шинжилгээний үр дүнгийн статистик үзүүлэлтийг Oasis Montaj Geosoft программаар боловсруулалт хийж төслийн талбайн сонгосон элементүүдийн дундаж дэвсгэр утгыг тогтоосон.

Хүснэгт 18 Хөрсний химийн үзүүлэлтүүдийн дэвсгэр утга

Элемент	Нэгж	Хамгийн их утга	Хамгийн бага утга	ундаж мг/кг
As	мг/кг	1,918.64	5.10	175.72
Ca	%	5.95	0.42	3.46
Cd	мг/кг	13.34	5.61	7.76
Cr	мг/кг	112.76	8.46	55.23
Cu	мг/кг	52.29	20.95	7.63
Fe	%	5.83	2.56	3.42
K	мг/кг	0.85	0.25	0.44
Mn	мг/кг	754.72	186.87	614.35
Mo	мг/кг	5.15	0.72	2.62
Ni	мг/кг	44.99	2.72	32.04
P	мг/кг	1,430.44	472.86	695.87
Pb	мг/кг	24.38	4.96	12.74
V	мг/кг	69.35	20.71	58.85
Zn	мг/кг	116.80	61.09	85.68

Хөрсний лабораторийн шинжилгээний үр дүнгээр илэрсэн элементүүдээр тархалтын зураг боловсруулсан ба тэдгээрээс хөрсний бохирдлыг тодорхойлох зорилгоор MNS 5850:2019, Талбайн хөрсний гео дундаж утга, Дэлхийн хөрсний кларк агуулгын дундаж утга зэрэгтэй харьцуулсан.




График 16 Хөрсөн дэх хүнцлийн агууламж




График 17 Хөрсөн дэх хромын агууламж




График 18 Хөрсөн дэх кобалтын агууламж

Хөрсөн дэх хүнд элементүүдийн тайлал:

Хүнцэл: Хүнцэл/As/ нь лабораторийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжид хамгийн бага агуулга 5.8 мг/кг, хамгийн их утга нь 192.60 мг/кг хүртэл ба дундаж утга нь 38.4 мг/кг байна. MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 20 мг/кг-аас илүү гарсан үр дүн Khas-08, Khas-010, Khas-028, Бутлуур – 1, Бутлуур – 2, Бутлуур 3, Бутлуур – 4, Баяжуулах үйлдвэр – 1, Зүүн кемп, Шимт хөрсний овоолго, Доод овоолго орчмын цэгүүд байна.

Эдгээр цэгүүдийн утгуудын бохирдлын индексийг тооцоолж тухайн орчинд нөлөөлөх эсэхийг Nakanson –ы томъёогоор тооцоолов.

Дээрх аргаар тооцоолол хийж үзвэл төслийн талбайд илэрсэн хүнцлийн агуулгын экологит үзүүлэх эрсдэлийн утга 0-2.41 хүртэл байгаа тул эрсдэлгүй байна.

Зэс: Зэс/Cu/ нь лабораторийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжид хамгийн бага агуулга 27 мг/кг, хамгийн их утга нь 53 мг/кг хүртэл ба дундаж утга нь 42 мг/кг байна. MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 100 мг/кг-аас давсан үр дүн байхгүй байна.

Хартугалга: Хар тугалга/Pb/ нь лабораторийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжинд хамгийн бага агуулга 14 мг/кг, хамгийн их утга нь 39 мг/кг хүртэл, дундаж утга нь 26 мг/кг байна. MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 100 мг/кг-аас давсан үр дүн байхгүй байна.

Хром: Хром/Cr/ нь лабораторийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжид хамгийн бага агуулга 34 мг/кг, хамгийн их утга нь 69.6 мг/кг хүртэл, дундаж утга нь 51 мг/кг байна. MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 150 мг/кг-аас давсан үр дүн байхгүй байна.

Ванади: Ванади/V/ нь лабораторийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжинд хамгийн бага агуулга 46 мг/кг, хамгийн их утга нь 73 мг/кг хүртэл, дундаж утга нь 60 мг/кг байна. MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 150 мг/кг-аас давсан үр дүн байхгүй байна.

Бусад молибден, кадми, селен, мөнгөн ус, сурьма зэрэг элементүүдийн шинжилгээний тодорхойлох доод утгаас бага, MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үр дүн байхгүй байна.

Цаашид хөрсийг бохирдохоос сэргийлж дараах арга хэмжээг авах нь зүйтэй.

Үүнд: Байгаль орчны хяналт шинжилгээ 72 Авто машины хэрэглэсэн тос, тослох бүтээгдэхүүн болон түлшийг ил задгай асгахгүй, хөрсөнд шууд хаяхгүй байх Хатуу болон шингэн хог хаягдлыг ил задгай хаяж асгахгүй байх Нүхэн жорлонг тогтмол ариутгах, бохир халихаас сэргийлэх Бохирдсон хөрсөнд агуулагдаж буй хүнд металлууд, элдэв эмгэг үүсгэгч нянгууд хур борооны усаар дамжин гүний худгуудад орохоос сэргийлж худгуудад хаалт, хашлага, барих Хог хаягдал түр хадгалах цэгүүдийг хаягжуулж, доодох талбайг нь бетондох, хаягдал хальж асгарахааргүй, шингэн хаягдал нэвчихээргүй сав суурилуулах Бохирдсон хөрсний бохирдол нь худгийн усруу орж түүгээр мал амьтан болон нутгийн иргэд ундаж болзошгүй талаар сэрэмжлүүлэг, таниулга хийх. Хөрсөн дэх цианид Хөрсөн дэх цианидын агуулгыг нэрэх-спектрофотометрийн аргаар Геологийн төв лаборатори ТӨҮГ-т тодорхойлов. Хүснэгт 35 Хөрсөн дэх нийт цианийн үр дүн Дээжийн байршил Элемент, мг/кг CN- нийт Khas-010 нь лабораторийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжид хамгийн бага агуулга 27 мг/кг, хамгийн их утга нь 53 мг/кг хүртэл ба дундаж утга нь 42 мг/кг байна.

MNS 5850:2019 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 100 мг/кг-аас давсан үр дүн байхгүй байна.

9.2. Усны чанарын хяналт шинжилгээ:

БОМТ 2023-ын дагуу усны хяналт шинжилгээг гадаргын болон гүний усны худгуудад сарын давтамжтайгаар хөндлөнгийн байгууллагатай хамтран хийж байгаа бөгөөд орон нутгийн иргэд болон мэргэжилтнүүдтэй улирал тутам хийж үр дүнг 2 лабораторид шинжлүүлэн харьцуулсан дүгнэлтийг хийж байна. Усны чанарын шинжилгээний үр дүнд үндэслэн ХЦ-4 худгаас ундны усны хэрэгцээг хангаж байна. Шинжилгээний үр дүнгээр унд ахуйн усны шаардлага хангахгүй учраас өрөмдлөг, зам усалгааны усыг үйлдвэрлэлийн усан хангамжийн ХЦ-2, Худаг -3 зэрэг худгаас хангаж байна.

Төслийн талбайд байрлаж буй нийт худгуудын усны түвшний 2023 оны 06-р сарын хэмжилтийн үр дүнг 2021 он болон 2022 оны түвшинтэй харьцуулахад түвшингийн бууралт үүсээгүй байна.

Үзүүлэлт тус бүрийг MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандартад заагдсан зарим утгуудтай болон 2021 онд шинжилсэн утгатай харьцуулан графикаар доор харууллаа.




График 19 Усны түвшин хэмжилтийн үр дүн

Тус үзүүлэлтээс үзэхэд “Хан Алтай” төслийн талбайн 11 цэгт усны түвшин байгаль цаг уурын бага зэрэг өөрчлөлт ажиглагдсан бөгөөд төслийн үйл ажиллагаанаас шууд хамаарсан өөрчлөлт гараагүй байна.




График 20 Усан дахь Кальцийн агууламж

Үүнээс харахад ЭЦ-4а, ХЦ-1, ХЦ-2, ХЦ-7, ХЦ-9, Багацахир булаг, Элгэн булаг, Бөөр булаг, МЦ-1, ХЦ-11, Гол-1, 30-н тн усны сав цэгүүдийн усан дахь кальцийн агуулга MNS 0900:2018 стандарт дахь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн байгаа ч 2021 оны 2022 оны дундаж суурь утгад өндөр байсан ба 2023 оны 06-р сарын үр дүнд өөрчлөлт ороогүй байна.




График 21 Усан дахь Магнийн агууламж

Магнийн агуулга ЭЦ-4а, ХЦ-1, ХЦ-2, ХЦ-6, ХЦ-7, ХЦ-9, Багацахир булаг, Элгэн булаг, Бөөр булаг, МЦ-1, ХЦ-11, MW-5, Гол-1, 30-н тн усны сав зэргийн ус нь стандартад заасан хэмжээнээс өндөр байгаа ч 2021 оны 2022 оны дундаж суурь утгад өндөр байсан ба 2023 оны 06-р сарын үр дүнд өөрчлөлт ороогүй байна.




График 22 Усан дахь Сульфатын агууламж

Сульфат ионы агуулга ХЦ-1, ХЦ-2, ХЦ-9, ХЦ-7, Багацахир булаг, Элгэн булаг, Бөөр булаг, МЦ-1, ХЦ-11, MW-5, гол-1 ус нь стандартад заасан хэмжээнээс их байгаа ч өндөр байгааг 2021 оны 2022 оны дундаж суурь утгад өндөр байсан ба 2023 оны 06-р сарын үр дүнд өөрчлөлт ороогүй бөгөөд эдгээр нь усны байгалийн өөрийн гарал үүсэл, тогтоцтой холбоотой юм.




График 23 Усан дах Нитрит агууламж


ХЦ-6 худгийн усны манганы агуулга стандартад заасан хэмжээнээс их өндөр байгаа ч 2021 оны 2022 оны дундаж суурь утгад өндөр байсан 2023 оны 06-р сарын үр дүнд өөрчлөлт ороогүй бөгөөд эдгээр нь усны байгалийн өөрийн гарал үүсэл, тогтоцтой холбоотой юм.

9.3. Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо, дундаж өндөр, бүрхэц, %

УРГАМЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Бид энэхүү судалгаагаар Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт орших Хан Алтай Ресурс ХХК-ны MV-021537 тоот уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн ургамлын аймаг, ургамалжилтыг судлах зорилгоор гуурст дээд ургамлын зүйлийн бүрдлийг гаргах, тэдгээрийн ховордол болон хамгааллын зэрэглэлийг тодорхойлох; ургамалжилтын ялгаатай хэсгүүдэд геоботаникийн бичиглэл хийж ургамалжилтын бүлгэмдлийг тодорхойлох, ургамалжилтын зургийг гаргах зорилтууд тавин ажилласан.

Хээрийн судалгааг 2023 оны 08 сарын 24-26-ний өдрүүдэд хийж гүйцэтгэсэн бөгөөд талбайн хэмжээнд 120 гаруй км замыг туулж нийт 14 цэгт геоботаникийн бичиглэл хийлээ.



Зураг 87. Уурхайн талбай болон хээрийн судалгаа хийсэн замнал

Төслийн талбайн ургамлын зүйлийн бүрэлдэхүүн

Судалгаа явуулсан нутагт Нүцгэн үрт (*Gymnospermae*) ба Далд үрт ургамлын (*Angiospermae*) томоохон бүлэгт хамрагдах 32 овог, 85 төрлийн 127 зүйл ургамал бүртгэгдсэн Ургамлын ангилал зүйг нэгжүүдийг тус бүр цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулсан. Энэ удаагийн судалгаагаар бүртгэсэн зүйлүүд нь Их нууруудын хотгорын цөлөрхөг хээрийн тойргийн ургамлын 29.33%-ийг эзэлж байна. Харин төсөөтэйн үзүүлэлтийг Их нууруудын хотгорын цөлөрхөг хээрийн тойрогтой харьцуулснаар 0.2267 гэсэн коэффициентийг үзүүлж байна.

Зүйлийн бүрдлийн судалгаагаар Шувуун нударгатын (*Pteridophyte*) хүрээнд хамаарах зүйл одоогоор бүртгэгдээгүй, харин Нүцгэн үрт (*Gymnospermae*) ургамлын хүрээнд 1 овогт хамаарах 1 төрлийн 1 зүйл ургамал (Нангиад зээргэнэ *Ephedra sinica* Stapf), нийт зүйлийн бүрдлийн 0.79%; Далд үрт ургамлын (*Angiospermae*) бүлгийг 2 ангилан, Нэг талт үрт ургамлын (*Monocotyledones*) ангид 5 овог, 11 төрлийн 21 зүйл, нэг дэд зүйл, нийт зүйлийн бүрдлийн 17.32%; Хос талт үрт ургамлын (*Dicotyledones*) ангид 26 овог, 67 төрлийн 101 зүйл, 2 дэд зүйл, 1 вариаци бүртгэгдэж нийт зүйлийн бүрдлийн 81.89%-ийг эзэлж байна.

Хүснэгт 19. Судалгааны талбайд бүртгэгдсэн ургамлын ангиллын бүтэц

Ангиллын үндсэн бүлгүүд		Овог	Төрөл	Зүйл	Дэд зүйл	Варианц	Эзлэх хувь
Бүгд		32	85	127			100
Pteridophyte		-	-	-			-
Gymnospermae		1	1	1			0.79
Angiospermae	Monocotyledones	5	17	21	1		17.32
	Dicotyledones	26	67	101	2	1	81.89


Бүртгэлд хамрагдсан ургамлуудын овгийг эзлэх хувиар илэрхийлэн үзвэл Нийлмэл цэцэгтэн (Asteraceae) 14.60%, Луультан (Amaranthaceae) 12.41%, Буурцагтан (Fabaceae) 6.57% , Саргайтан (Rosaceae) 5.84% овгууд хамгийн өндөр хувь үзүүлж байна Эдгээр 4 овгууд нь нийт бүртгэгдсэн зүйлүүдийн 39.42%-ийг бүрдүүлж байна.

Хүснэгт 20. Овог тус бүрд эзлэх зүйлийн бүрэлдэхүүн, эзлэх хувь (%)

№	Овгийн латин нэр	Овгийн монгол нэр	Зүйлийн тоо	Эзлэх хувь
1	Asteraceae	Нийлмэл цэцэгтэн	20	14.60
2	Amaranthaceae	Луультан	17	12.41
3	Fabaceae	Буурцагтан	9	6.57
4	Rosaceae	Саргайтан	8	5.84
5	Caryophyllaceae	Баширтан	6	4.38
6	Brassicaceae	Байцаатан	5	3.65
7	Amaryllidaceae	Сонгинтон	4	2.92
8	Lamiaceae	Мажтан	4	2.92
9	Crassulaceae	Зузаалайтан	3	2.19
10	Polygonaceae	Тарнатан	3	2.19
11	Primulaceae	Хаварсалтан	3	2.19
12	Ranunculaceae	Холтсон цэцэгтэн	3	2.19
13	Boraginaceae	Ноцоргонотон	2	1.46
14	Convolvulaceae	Сэдэргэнтэн	2	1.46
15	Gentianaceae	Дэгдтэн	2	1.46
16	Nitrariaceae	Хармагтан	2	1.46
17	Zygophyllaceae	Хотиртон	2	1.46
18	Apiaceae	Шүхэртэн	1	0.73
19	Caprifoliaceae	Далан хальстан	1	0.73

20	Geraniaceae	Шимтэглэйтэн	1	0.73
21	Onagraceae	Хөвөнтөн	1	0.73
22	Plantaginaceae	Таван салаатан	1	0.73
23	Plumbaginaceae	Хорголжинтон	1	0.73
24	Scrophulariaceae	Иршимбэтэн	1	0.73
25	Tamaricaceae	Сухайтан	1	0.73
26	Urticaceae	Халгайтэн	1	0.73
Нийт			127	100%

График
24.



Бүртгэгдсэн зүйлүүдийн овгийн бүрэлдэхүүн

Төслийн талбайн ховор болон ашигт, эмийн ургамлын судалгаа

Хээрийн судалгаагаар бүртгэгдээд буй 127 зүйл ургамлыг бүс нутгийн хэмжээний Улаан дансны бүртгэлийн дагуу шүүж үзэхэд Товчин дэвхэргэнэ (*Eremogone androsacea* (Grubov) Ikonn.) хэмээх зүйл Устаж болзошгүй (EN) зэрэглэлд, Дэрэн ажигана (*Stellaria pulvinata* Grubov), гэсэн зүйл Эмзэг (VU) зэрэглэлд бүртгэлтэй байна (Зураг 12-13).

Монгол улсын улаан номд бүртгэгдсэн ургамлын зүйд энэ удаагийн хээрийн судалгаагаар бүртгэгдээгүй болно.

Хүснэгт 21. Ховор ургамлын жагсаалт

№	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Олон улсын улаан дансны үнэлгээ	Бүс нутгийн улаан дансны үнэлгээ
1	<i>Eremogone androsacea</i>	Товчин дэвхэргэнэ		Устаж болзошгүй
2	<i>Stellaria pulvinata</i>	Дэрэн ажигана		Эмзэг

Дээрх 2 зүйл ургамал нь тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хойд хагаст бүртгэгдсэн болно.

Энэхүү судалгааны хүрээнд 32 овог, 85 төрлийн 127 зүйл ургамал тархсаныг тодорхойлсноос гадна зургаан томоохон бүлгэмдэл илрүүлээ. Үүнд таана давамгайлсан буюу таанат, баглуурт, боролзот, ерхөгт, бушилзат, хялганат бүлгэмдлүүд болно.

Бүртгэгдсэн нийт ургамлыг амьдралын хэлбэрээр ангилан үзвэл хамгийн их хувийг олон наст өвслөг ургамал 86 зүйл (нийт бүртгэгдсэн зүйлийн 68% эзэлнэ), түүний дараа нэг наст өвслөг ургамлууд 25 (20%), хамгийн бага хувийг сөөг, сөөгөнцөр ургамлууд 16 (12%) эзлэх ба энэ удаагийн судалгаанд мод, модлог ургамлын зүйлүүд хараахан бүртгэгдээгүй болно.

Тусгай зөвшөөрлийн талбайн зүүн хойд хагаст буюу өндөр уулын бүсэд бүс нутгийн улаан дансны шалгуур үнэлгээгээр “Эмзэг” статусаар үнэлэгдсэн дэрэн ажигана (*Stellaria pulvinata*), “Устаж болзошгүй” товчин дэвхэргэнэ (*Eremogone androsacea*) хэмээх 2 зүйл тэмдэглэгдсэн. Монгол улсын улаан номд бүртгэгдсэн ургамлын зүйл бүртгэгдээгүй бөгөөд эмийн болон ашигт ургамлын 37 (эмийн түүхий эд болдог 32, хүнсэнд өргөн хэрэглэдэг 5) зүйл тархсан байна.

Хээрийн судалгаа,геоботаникийн бичиглэл, газрын гадаргын хэв шинж, амьдрах орчны (ургамал ургах орчин) ялгаатай байдал зэрэг мэдээлэлд үндэслэн тусгай зөвшөөрлийн хэмжээнд ургамалжилтын хэв шинжийн ялгаатай байдлыг газар зүйн мэдээллийн систем (ArcMap) ашиглан зураглалаа. Ингэхэд боролз-орог тэсэгт сайрын хэв шинж хамгийн их талбайд буюу 1420 га (20.90%) тархсан бол таанат цөлөрхөг хээр 1292 га (19.02%), баглуур-боролзот цөлөрхөг хээр 1216,16 га (17.90%), Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хээр 975 га (14.35%), Хялгана таанат хээр 863 га (12.70%), Үетэнт -дэвхэргэнт уулын хээр 678 га (9.98%), Бушилзит өндөр уулын нуга 194 га (2.86%), Харгана бүхий сайр 155 га (2.28%) буюу нийт 8 хэв шинж тархсан байна.

Төслийн талбайн NDVI тодорхойлохдоо Sentinel-2 хиймэл дагуулын 20 метрийн нарийвчлалтай зургийг ашиглаж 2020-2023 оны хооронд VII-VIII сарууд буюу ургамлын ногоорлын үеийг хамруулж 9 зурагт боловсруулалт боловсруулалт хийхэд 2021 оны VIII сар зуншлага хамгийн сайн байсан бол 2022 оны VII/28 зуншлага тааруухан байжээ. Бидний ургамлын хээрийн судалгаа хийсэн цаг хугацаанд буюу 2023 оны VIII/27 -ны өдрийн утга өмнөх онуудын дунджаас 0.02 баллаар бага байна.

9.4. Орчны физик үзүүлэлтүүдийн мониторинг

Агаарын чанарын хяналтын мониторингийн бас нэг бүрэлдэхүүн хэсэг нь ажлын байрны дуу чимээ, харьцангуй чийгшлийн хэмжилтүүд байлаа. Тухайн үзүүлэлтүүдийг хэмжиж, ажлын байрны агаарын чанарын стандарттай харьцуулж дүгнэв.

Хүдэр баяжуулах үйлдвэр бүрэн ашиглалтанд орж, химийн бодис урвалж ашиглаж эхлэхэд цианидын натри байгальд өөрөө задарч синилийн хүчил үүсгэх орчны физик хүчин зүйл нь харьцангуй чийгшил юм.




График 25 Харьцангуй чийгшлийн хэмжээ

Дуу чимээний үзүүлэлт:

Дуу чимээг Баяжуулах үйлдвэрийн дотор талд UT353BT төхөөрөмжөөр ISO EN 9614-1 Акустикууд- Дуу чимээний эрчим хүчийг ашиглан дуу чимээний эх үүсвэрийн дуу чимээний эрчим хүчний түвшинг тодорхойлох аргаар хэмжив. Өдрийн цагт зөвшөөрөгдөх хэмжээ 60 дБА (MNS 4585:2007 Агаарын чанарын стандарт) бөгөөд 2023 оны 06-р сарын 23-ны өдөр төслийн талбайн баяжуулах үйлдвэрийн орчим хэмжсэн утга 77.8-85.8 дБА байна




График 26 Дуу чимээний хэмжилт

Орчны физик үзүүлэлтүүдийн дүгнэлт:

Ажлын байрны агаарын чанарын дээрх 2 үзүүлэлтээс дүгнэхэд харьцангуй чийгшил хяналтын хэсгүүдэд хэвийн байна. Харин дуу чимээний төвшин бутлуурын үйлдвэр, өрөмдлөг эрэл хайгуул, хүдэр боловсруулах үйлдвэр, засвар, гагнуурын цехүүдэд стандартаас давсан үзүүлэлтүүд бүртгэгдсэн байна. Тухайн орчинд ажиллаж буй ажилчид сонсгол хамгаалах хэрэгслийг тогтмол хэрэглэх шаардлагатай бөгөөд дуу чимээ ихээр үүсгэж буй тоног төхөөрөмж, суурин болон хөдөлгөөнт техникийг ажиллах цаг хугацааг тодорхой давтамжтай хязгаарлах, дуу намгагч суурилуулах, дуу шингээгчээр тоноглох, ажилтныг ажиллах цагийг хязгаарлах зэрэг хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай. Тухайн арга хэмжээнүүдийг жил бүрийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт системтэйгээр хэрэгжүүлэн ажиллана.

БҮЛЭГ АРАВ. АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

“Хан Алтай” төсөл нь Говь-Алтай аймгийн Засаг дарга, Есөнбулаг сумын Засаг даргатай гурвалсан “Нийгмийн хариуцлагын гэрээ”-г жил бүр байгуулж тус гэрээний дагуу “Орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна: Энэхүү “хөтөлбөрийн зорилго нь Хан Алтай Ресурс ХХК-ийн аюулгүй, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлж, орон нутагт эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгох, иргэдийн боловсрол, эрүүл аюулгүй амьдралын орчинг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, иргэдийн оролцоотой байгаль хамгаалал, хяналт, шинжилгээг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулахад оршино.

Хөтөлбөр нь Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд хэрэгжих ба сумын засаг дарга, орон нутгийн иргэдийн санал, аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан урт болон богино хугацаанд дараах хөтөлбөрүүдийн дагуу хэрэгжинэ. Үүнд:

Хөтөлбөр 1. Соёлын өвийг хамгаалах

Хөтөлбөр 2. Орон нутгийн иргэдийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих

Хөтөлбөр 3. Орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх


Хөтөлбөр 4. Орон нутгийн бизнес, эдийн засгийг дэмжих

Хөтөлбөр 5. Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээ зэрэг болно.

Хан Алтай Ресурс ХХК-иас хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг аймаг, орон нутгийн иргэдэд жилд нэг удаа мэдээлэхээс гадна жилийн эцэст тухайн жилийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх, мөн дараа жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг орон нутгийн удирдлага, иргэдийн саналд тулгуурлан хэлэлцэн батлах уулзалтыг төслийн оролцогч талуудтай хамтран зохион байгуулна. ОНХХ нь үндсэн 5 хөтөлбөр, 14 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилладаг. 2023 онд “Орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилт 92 хувийн гүйцэтгэлтэйгээр орон нутгийн хамтын ажиллагааг улам төгөлдөржүүлэн ажиллаж байна.

5 ДЭД ХӨТӨЛБӨР, 14 ЗОРИЛТ

**2023 онд 825 сая төгрөг
34 үйл ажиллагаа**



БҮЛЭГ АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Удирдлага, зохион байгуулалтын ерөнхий төлөвлөлт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1		Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан БОННУ-нд тодотгол хийж БОАЖЯ-аар батлуулах	Бүрэн хэрэгжсэн	“Хан алтай ресурс” ххк-ийн Говь-алтай аймгийн Есөнбулаг сумын нутагт орших “Хан-алтайн алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах, Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах аргаар баяжуулах үйлдвэрийн төсөл”-ийн БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭЛТ ТОДОТГОЛЫГ БОАЖЯ-аар хэлэлцүүлж дэмжих саналтайгаар батлуулсан.
2	Жил бүр дараах ажлуудыг гүйцэтгэж, холбогдох зөвшөөрлүүдийг сунгуулж, гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах	БОМТ-ын төлөвлөгөөг БОАЖГ-аар хянуулж БОАЖЯ-аар батлуулж хэрэгжилтийг хангах	Бүрэн хэрэгжсэн	Хан Алтай төслийн БОНБНУ, байгаль орчны 5 жилийн менежмент төлөвлөгөөнд үндэслэн, жил бүр БОМТ боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 БОМТ-г БОАЖЯ-р батлуулж биелэлтийн тайланг боловсруулан, ажлын хэсэгт тогтоосон хугацаанд тайлагнахаар төлөвлөн ажиллаж байна.
3		Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах	Тогтмол хэрэгжүүлж байна	Хяргас нуур – Завхан голын сав газрын захиргаатай байгуулсан 2023 оны 06-р сарын 07-ний өдрийн №06 дугаар бүхий гэрээгээр нийт 523.590,41 м3/жил ус ашиглахаар гэрээ байгуулсан. Тухайн хэмжээний усыг нийт 7 гүний цооногоос авч ашиглахаар төлөвлөсөн.

				<p>Одоогоор нийт 3 цооногоос унд ахуй болон үйлдвэрлэлийн усан хангамжийг авч ашиглаж байна.</p> <p>Унд ахуй болон үйлдвэрлэлд ашигласан усны бүртгэлийг сар тутамд бүртгэж, улирал тутамд холбогдох төлбөрийн ноогдуулалтыг хийж байна.</p>
4		Ус ашиглалтын мэдээ тайланг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэх	Тогтмол хэрэгжүүлж байна	<p>2023 оны эхний 3 улирлын байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Ашигт малтмал олборлох – 132,824 м3 ✓ Зам талбайн усалгаа – 72,473 м3 ✓ Эрэл, өрөмдлөг хайгуулд – 43,089 м3 ✓ Ногоон байгууламж, усалгаанд – 106 м3 ✓ Унд ахуйд – 10,467 м3 ✓ Дулаан хангамж – 14,745 м3 ✓ Барилга байгууламж – 1,336 м3 тус тус усыг зарцуулаад байна. <p>Ус ашиглалтын тайланг сар бүр тогтмол бүртгэн тэмдэглэж байгаа бөгөөд улирал тутамд төлбөрийн ноогдуулалтыг хийж байна.</p>
5	Байгаль орчинтой холбоотой давтамжтай ажлуудыг цаг тухайд нь мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байх	Мэргэжлийн байгууллагатай хамтран хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах гэрээг хийж, гүйцэтгэлийг хангах	Тогтмол хэрэгжүүлж байна	<p>2023 онд Хог хаягдлын тухай хуулийн дагуу энгийн хог хаягдлыг Говь-Алтай аймгийн “Хот тохижуулах газар”-тай гэрээ байгуулан ажилласан. Төслийн талбайд энгийн хог хаягдлыг ангилан ялгаж энгийн хог хаягдлыг кемпийн нэгдсэн хог хаягдлын түр цэгт төвлөрүүлж ачуулан тээвэрлэх замаар аймгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэсэн</p> <p>Тус ажлын хүрээнд “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”-тай 2023 оны 12 дүгээр сарын 31-ны өдрийг дуустал үйл ажиллагаанаас гарсан энгийн хог хаягдлыг Алтай хотын нэгдсэн хогийн цэгт хүргэх, хог хаягдлын хэмжээгээр татвар хураамжийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны 10-р сарын байдлаар 299.9 тонн энгийн хог</p>

				хаягдлыг Алтай хотын нэгдсэн хогийн цэгт хүргэсэн байна.
6		Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах олборлох гэрээг Есөнбулаг сумын ЗДТГ-тай байгуулах	Бүрэн хэрэгжсэн	Газрын хэвлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Төсвийн тухай хууль 23-р зүйлийн 8.8 дугаар заалтыг үндэслэн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын БОХУБ Э.Энхбаатар-тай түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талаар харилцан тохиролцож Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах олборлох гэрээг 2023.03.23нд байгуулсан. Гэрээний эх хувийг хавсралтаар оруулж өгөв.
7	Дотоод хяналт үнэлгээ	Ус, газар, хог хаягдал, түгээмэл тархацтай ашигт малтмал, агаарын бохирдлын хураамжийг гэрээний дагуу төлөвлөгөөт хугацаанд барагдуулах	Бүрэн хэрэгжсэн	Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн хураамжийг холбогдох эрхзүйн дүрэм, журам, тушаал шийдвэрт үндэслэн, баримтжуулалт хийж холбогдох төлбөрийг сум орон нутгийн дансанд төвлөрүүлж байна. Төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар оруулж өгөв.
8		Орон нутгийн төрийн захиргааны байгууллагтай хамтран байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр арга хэмжээ зохион байгуулах		Говь-Алтай аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 61 тоот “Хамтран ажиллах санал хүргүүлэх тухай” албан хүсэлтийн дагуу 2023 онд Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа, Хяргас нуур Завхан голын сав газрын захиргаатай хамтран эко клубүүдийн хүүхдүүдийн дунд “Хүрээлэн буй орчин ба физик мэтгэлцэн”-ийг 5.000.000 төгрөгөөр, эко клубүүдийн хүүхдүүдийн үйл ажиллагааг дэмжих, сургалт зохион байгуулах зардалд 1.000.000 төгрөг, Цөлжилттэй тэмцэх өдрийн арга хэмжээнд 2.000.000 төгрөг, Дэлхийн усны өдрийн арга хэмжээнд 5,000,000 төгрөг, Сав газрын талуудын оролцооны зөвлөлийн хурал зохион байгуулах

				үйл ажиллагаанд 5,000,000 төгрөг, Хяргас нуур Завхан голын сав газрын захиргааны 5 жилийн ойн хүрээнд булаг хашиж хамгаалах үйл ажиллагаанд 3,000,000 төгрөг, нийт 21,000,000 төгрөгөөр дээрх үйл ажиллагаануудыг санхүүжүүлэн хамтран ажилласан.
9		Компанийн гүйцэтгэх захирлын баталсан орон тоонд үндэслэн байгаль орчны ажилтануудыг авч ажиллуулах	Бүрэн хэрэгжсэн	Компанийн гүйцэтгэх захирлын баталсан орон тоонд үндэслэн 2023 оны 07 дугаар сард Байгаль орчны зохицуулагч 1, Нөхөн сэргээлтийн мэргэжилтэн -1 тус тус авч ажиллуулж байна.

БҮЛЭГ АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зураг 4 Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжүүлж байна, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь үзэж шалгах ажлын хэсгийн үзлэг шалгалт	Төлөвлөгөөт шалгалт	БО-г хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон орчны хяналт шинжилгээний үр дүн	2023 оны 11 -р сар	Тогтмол хэрэгжүүлж байна	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 – ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан. /Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, Хянан батлах, тайлагнах журам/-ын дагуу 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулан БОАЖЯ-аар батлуулан гүйцэтгэлийг ханган 95 хувийн гүйцэтгэлтэйгээр сөрөг нөлөөллийг бууруулах олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ.
2	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг орон нутгийн захиргаанд хүргүүлэх, нөлөөллийн бүсийн багийн иргэдийн нийтийн болон иргэний хуралд тайлагнах	Олон нийтэд тайлагнах	2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн үр дүн	2023 оны 4 дүгээр улиралд	Тогтмол хэрэгжүүлж байна	
3	БОННУ-ний тодотголын тайланг Есөнбулаг сумын “Наран баг”-ын ИНХ-аар хэлэлцүүлэх	Олон нийтэд тайлагнаж санал авах	БОННУ-ний тайлан	2023 оны 1 дүгээр улиралд	Бүрэн хэрэгжсэн	Мөн Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Наран багийн 2023 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн Иргэдийн нийтийн хурлаар Грийн ассесмент ХХК-тай хамтран БОННУ-ний нэмэлт тодотгол тайланг танилцуулж дэмжигдсэн.